



The Asia Foundation

ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭДЭД НЭЭЛТТЭЙ БОЛГОХ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

(ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Гүйцэтгэгч: ХСИС-ийн Цагдаа судлалын төв

Улаанбаатар хот

2017 он

АГУУЛГА

Хүснэгт, графикийн жагсаалт.....	2
I. УДИРТГАЛ.....	3
1.1 Судалгааны ажлын зорилго, зорилт.....	3
1.2 Судалгааны онцлог тал.....	3
1.3 Судалгааны арга зүй, түүвэрлэлт.....	3
II. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	5
2.1 Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт.....	5
2.2 Иргэдийн дунд санал асуулгын аргаар явуулсан судалгааны үр дүн.....	7
2.3 Өмгөөлөгч нарын дунд ярилцлагын аргаар явуулсан судалгааны үр дүн.....	21
ДҮГНЭЛТ.....	27
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	29
ХАВСРАЛТ.....	30
Өмгөөлөгчдөөс хариулсан судалгааны дэлгэрэнгүй үр дүн.....	30

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт, графикийн жагсаалт

Хүснэгт 1.....	6
Хүснэгт 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдийн авч байсан мэдээлэл.....	11
Хүснэгт 3. Иргэдэд нээлттэй болгох шаардлагатай мэдээллийн жагсаалт	13
Хүснэгт 4. Иргэнд нээлттэй болгох шаардлагатай мэдээлэл.....	16
Хүснэгт 5. Мэдээлэл нээлттэй болгох хэлбэр.....	18
График 1. Судалгаанд оролцогчдын нас	7
График 2. Судалгаанд оролцогчдын нийгмийн байдал	7
График 3. Судалгаанд оролцогчдын байршил	8
График 4. Судалгаанд оролцогчдын байршил.....	9
График 5. Цагдаагийн байгууллагаас иргэдийн авч байсан мэдээлэл.....	9
График 6. Прокурорын байгууллагаас иргэдийн авч байсан мэдээлэл.....	10
График 7. Шүүхээс иргэдийн авч байсан мэдээлэл.....	11
График 8. Иргэдийн хүсэлтэд өгсөн хариултын агуулга	12
График 9. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлын талаарх иргэдийн төсөөлөл.....	19
График 10. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын харилцааны соёл, хандлага	20

I. УДИРТГАЛ

1.1 Судалгааны ажлын зорилго, зорилт

Энэхүү судалгааны ажлын зорилго нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдэд нээлттэй болгох мэдээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход оршино.

Зорилт:

Энэхүү зорилтоо хэргжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагаас мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх;
2. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдэд нээлттэй болгох мэдээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үүднээс иргэдийн дунд санал асуулгын аргаар судалгаа явуулж дүгнэлт хийх;
3. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдэд нээлттэй болгох мэдээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үүднээс өмгөөлөгч нарын дунд ярилцлагын аргаар судалгаа явуулж дүгнэлт хийх.

1.2 Судалгааны онцлог тал

Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал сэдвийн хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг төрийн байгууллага, авлига, засаглалын ил тод байлын хүрээнд төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачид цөөнгүй судалгаа хийсэн ч бүгд байгууллагын онцлогийг харгалзан судалсан байна.

Энэхүү судалгааны ажлын онцлог нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатан дахь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдэд нээлттэй болгох мэдээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон болно.

1.3 Судалгааны арга зүй, түүвэрлэлт

Энэ судалгааны ажлын дүгнэлт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байсан туршлагатай 99 иргэний дунд явуулсан санал асуулга, 57 өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагын судалгааны үр дүнд үндэслэсэн болно. Судалгааны санал асуулгын хуудас, өмгөөлөгч нартай хийх ярилцлагын асуултыг АНУ-ын Азийн сан, Улсын Ерөнхий прокурорын газрын холбогдох албан тушаалтантай хамтран боловсруулж, туршилтын судалгаа явуулсны үндсэн дээр судалгааг эхлүүлсэн.

Судалгаанд оролцогч иргэдийн түүвэрлэлтийг хийхдээ Архангай аймгийн Прокурор, Говьсүмбэр аймгийн Шүүх, Төв аймгийн цагдаагийн газар, Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтэст эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж байгаа 30, шүүхээс ял шийтгүүлж тэнсэгдэсэн 26, хорих ял эдлээд сулалгасан 19, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн 15 иргэнийг тус тус сонгож судалгаа явуулсан.

Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудаар үйлчлүүлж байсан, олон удаа мэдээ, мэдээллээ авахаар хүсэлт гаргаж, хандаж байсан туршлагатай Хүний эрхийн үндэсний комисс, төрийн бус байгууллагуудын ажилтнуудаас судалгаа авч, харилцан ярилцлаа. Цагдаа, Прокурор, Шүүхийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтнуудтай энэ талаар ярилцлага хийж, мэдээлэл цуглуулж авав.

Судалгаанд оролцсон өмгөөлөгч нарыг түүвэрлэхдээ Монголын Хуульчдын холбоонд бүртгэлтэй, эрүүгийн хэргийн талаар дагнан өмгөөлөлийн үйл ажиллагаа явуулдаг хуульч-өмгөөлөгч нараас 57 өмгөөлөгчийг сонгож ярилцлага хийсэн болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

II. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1 Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17-д “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй...” гэж заасан хүний суурь эрхийг баталгаажуулж төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Их хурлаас 2016 оны 06 дугаар сарын 16-ний өдөр **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг** батлан мөрдөж байна.

Тус хууль нь Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Хувь хүний нууцын тухай, Цагдаагийн албаны тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжид нийцэж гарсан бөгөөд хуульд хориглосноос бусад мэдээлэл авах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн. Энэ хуулиар иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг авч болохоор тодорхойлсон бөгөөд мэдээлэл авах хэлбэр, төрлийн нарийвчлан зохицуулсан.

Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглосон дараах нөхцөлийг хуульчилсан байна. Үүнд:

- тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа бол;
- тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой бол;
- **хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол;**
- тухайн мэдээлэл нь олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах явцтай холбоотой бол гэж тус тус заажээ.

Түүнчлэн, тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулах”, 20 дугаар зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулах”, 21 дүгээр зүйлд “Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн (гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд) бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг тус тус хориглосон байна.

Иймд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагаас мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа нь энэ хуулиар зохицуулагдах боловч **хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны явцад нууцалвал зохих мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэг хүлээхгүй юм.**

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 12 дугаар зүйлд Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууцыг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно гэж заасан нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч бүр хэргийн талаар бүх мэдээллийг шаардан авах эрх эдлэхгүй гэдгийг тодорхойлж байна. “Хүснэгт 1”-т үзүүлснээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн мэдээлэл авах хүрээ, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын мэдээлэл өгөх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 1.

<i>ЭБША-нд оролцогч</i>	<i>Мэдээлэл авах эрх</i>	<i>Мэдээлэл өгөх үүрэг</i>
<i>Сэжигтэн</i>	“...ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх”; “Өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах”.	...Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар хэрэгт сэрдэгдэж байгааг сэжигтэнд тэр даруй, түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн эсхүл өмгөөлөгчид нь 48 цагийн дотор мэдэгдэнэ.
<i>Яллагдагч</i>	...ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх; ...яллагдагчаар татсан болон таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах; ...өөрт холбогдсон хэргийн материалтай танилцах; ...шинжээч томилсон тогтоол болон шинжээчийн дүгнэлттэй танилцах.	...Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын бүх ажиллагааг хийж дууссан, хэргийг шийдвэрлэх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл энэ тухай яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгчид мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ.
<i>Өмгөөлөгч</i>	...өмгөөлж байгаа үйлчлүүлэгчийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж...; ...өөрийн байлцсан байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцах...; ...хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хатаст хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах;	...Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаныг мэдэгдэх, хэргийн материал танилцуулах
<i>Хохирогч</i>	...Хохирогч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хавтаст хэргийн бүх материалтай танилцах.	
<i>Иргэний нэхэмжлэгч, хариуцагч</i>	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссан үед хэргийн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгтэй танилцах.	
<i>Хөндлөнгийн гэрч</i>	...Хөндлөнгийн гэрч нь өөрийнхөө оролцсон байцаан шийтгэх ажиллагааны талаар гомдол гаргах, байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцах...	

Дээрх мэдээлэл авах эрх зүйн зохицуулалтанд дүн шинжилгээ хийж үзвэл **эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэргийн өөрт**

холбогдох мэдээллийг авах эрхтэй байдаг бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дуусмагц хэргийн материалтай бүхэлд нь танилцуулах үүрэгтэй байна.


2.2 Иргэдийн дунд санал асуулгын аргаар явуулсан судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгааны ажлын нэг зорилт нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг тодорхойлох явдал байсан бөгөөд энэ үүднээс тусгайлан боловсруулсан асуултаар хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаар үйлчлүүлж байсан **99 иргэний дунд судалгаа явуулж**, дүгнэлт хийсэн болно.


Судалгаанд оролцсон 99 иргэний 66 буюу 66.7% эрэгтэй, 33.3 буюу 33.3% нь эмэгтэй, 38 буюу 38.4% нь 18-30 насны, 37 буюу 37.4% нь 31-40 насны, 18 буюу 18.2% нь 41-50 насны, 5 буюу 5.1% нь 51-60 насны хүмүүс байна.

График 1. Судалгаанд оролцогчдын нас




Судалгаанд оролцогчдын нийгмийн байдлыг авч үзвэл 26 буюу 26.3 хувь нь төрийн алба хаагч, 22 буюу 22.2% нь хувийн хэвшлийн ажилчин, 33 буюу 33.3% нь хувиараа бизнес эрхлэгч, 9 буюу 9.1% нь эрхэлсэн ажилгүй, 5 буюу 5.1% нь оюутан, 6 буюу 6.1% нь өмгөөлөгч, 1 буюу 1% нь төрийн бус байгууллагын ажилтан тус тус байна. Үүний дотор 46.4% нь дунд сургууль, 4% нь коллеж, 6% нь дунд сургууль диплом, 23.2 хувь нь бүрэн дунд, 14.1% нь бүрэн бус дунд, 5.1% нь бага боловсролтой хүмүүс байсан.

График 2. Судалгаанд оролцогчдын нийгмийн байдал



Оршин суугж буй нутга дэвсгэрээр нь авч үзвэл 83.5% нь Улаанбаатар хот, 16.5% нь хөдөө орон нутгийн иргэд байсан байна.

График 3. Судалгаанд оролцогчдын байршил



Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн ерөнхий шинжийг авч үзвэл **эрүүгийн байцаан шийтгэх ажиллгаанд ямар нэгэн байдлаар оролцож байсан талаар өөрийн байр суурийг бүрэн илэрхийлэх боломжтой иргэд** гэж дүгнэв.

Судалгаанд оролцогчдын 66.7% нь эрэгтэй, 18-40 насны 70 орчим хувь, дээд боловсролтой иргэн 50 орчим хувийг эзэлж байгаа нь эрэгтэй, дээд боловсролтой, дундаж насныхан шүүх, хууль сахиулах байгууллагтай холбогдох нь түгээмэл байна гэж үзэж болно.

Асуулт-1. Та цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар ямар зорилгоор хандаж, харилцаж байсан бэ?

Гэмт хэргийн хохирогч болж, эрх ашгаа хамгаалуулахаар хандаж байсан гэж 42 буюу 42.4 хувь, гэмт хэрэг, зөрчилд холбогдож шалгагдаж байсан гэж 39 буюу 39.4 хувь, Гэмт хэргийн халдлагад өртсөн иргэн, байгууллагын эрх ашгийг хамгаалахад өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байсан гэж 9 буюу 9.1 хувь, гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байсан гэж 8 буюу 8.1 хувь, гэр бүл, хамаатан садныхаа эрх ашгийг хамгаалахаар холбогдож байсан гэж

18 буюу 18.2 хувь, ажлын шугамаар эрх зүйн туслалцаа үзүүлж хандаж байсан гэж 1 буюу 1.0 хувь, асуудал гараад зөвлөгөө авахаар хандаж байсан гэж 2 буюу 2.0 хувь, гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд туслахаар хандаж байсан, 1 буюу 1.0 хувь нь хэргийг цагдаад мэдээлэх, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байсан, ажлын шугамаар гэж 3 буюу 3.0 хувь нь тус тус хариулсан байна.

График 4. Судалгаанд оролцогчдын байршил




Дээрх судалгааны дүнгээс үзвэл иргэд гэмт хэрэг зөрчилд холбогдсон гэсэн шалтгаанаар хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагатай хамгийн их холбогддог бол хэргийг мэдээлэх зорилгоор цагдаад хандаж байсан гэж үзжээ.

Асуулт-2. “Та цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхээс байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх ямар мэдээ, мэдээлэл авч байсан бэ?”

Шүүх, хууль сахиулах байгууллагуудаас авч байсан мэдээ, мэдээллийг тодорхойлох зорилгоор “Та цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх ямар мэдээ, мэдээлэл авч байсан бэ?” гэсэн асуулт тавьж хариултыг байгууллага тус бүрээр нь ангилан гаргасан болно.

График 5. Цагдаагийн байгууллагаас иргэдийн авч байсан мэдээлэл



Дээрх судалгааны дүнгээс үзвэл иргэд гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл хамгийн ихээр авдаг бол гомдол мэдээлэл, шалгаж буй алба хаагчдын талаарх мэдээлэл, хэрэгсэхгүй болгосон санал гаргасан байдал, байцаан шийтгэх ажиллагааны явц байдлын талаар мөн мэдээлэл авдаг байна. Харин эрүүгийн хэрэгт хамааралтай бусад хүний талаарх мэдээлэл авдаг гэсэн хариулт хамгийн бага буюу нийт оролцогчийн 5% нь хариулсан нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад зөвхөн өөртэй нь холбоотой мэдээллийг танилцуулдагтай холбоотой.

Бид судалгааны ажлын явцад алба хаагчдын нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар нээлттэй байдаг эсэх талаар тодруулж үзэхэд Улаанбаатар хотын цагдаагийн газрын харьяа Баянзүрх, Сүхбаатар дүргийн цагдаагийн хэлтсийн алба хаагчдын нэр, албан тушаал, цол, холбоо барих утасны дугаар нь өрөөний үүдэнд маш тодорхой байдлаар байршуулсан байна. Харин иргэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хувийн байдалтай холбоотой мэдээлэл авах сонирхол ихтэй байдаг байна. Тухайлбал, гэрийн хаяг, төрсөн газар, найз нөхөд гэх мэт.


Харин иргэд прокурорын байгууллагаас авдаг мэдээллийг График 6-г үзүүлсэн байна. судалгаанд оролцогчдын 29 буюу 29.3% нь прокурорын шийдвэрийн талаар мэдээлэл авч байсан гэж хариулсан бол эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй прокурорын нэрийг мэдэхийг хүсдэг байна. Түүнчлэн, хавтаст хэрэгт холбогдох зарим мэдээллийн талаар мэдээлэл авдаг гэсэн хариултыг 18.2% нь тус тус сонгосон байна. Харин эрүүгийн хэргийг хүлээн авсан огноо, прокурорын шийдвэрт гомдол гаргах гэсэн хариултыг хамгийн их сонгосон байна.

График 6. Прокурорын байгууллагаас иргэдийн авч байсан мэдээлэл



Шүүхээс авдаг мэдээллийн төрлийг график 7-т үзүүлсэн болно. Судалгаанд оролцогчдын 37 буюу 37.4% нь шүүхийн шийдвэрийн талаар мэдээлэл авдаг гэсэн бол оролцогчдын 27.3% нь шүүх хуралдааны тов, бүрэлдэхүүний талаар, 18.2% нь хэрэг хянан шийдвэрлэх шүүгчийн нэр, 17% нь шүүх хэргийг хүлээн авсан он, сар, өдрийн талаар мэдээлэл тус тус авсан байна.

График 7. Шүүхээс иргэдийн авч байсан мэдээлэл



Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн болон цагдан хорих, баривчлах тогтоол гармагц, сэжигдэн, яллагдагч, шүүгдэгч болон түүний гэр бүлийн гишүүн, өмгөөлөгчид нь мэдэгдэх үүрэгтэй гэж заасантай холбоотойгоор энэхүү мэдээлэл авах эрх нээлттэй байдаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авдаг мэдээллийг хүснэгт 1-т үзүүлэв. Судалгаанд оролцогчдын 30 буюу 30.3% нь шүүхийн шийдвэр хэрэгжиж эхэлсэн талаар мэдээлэл авадаг бол 21 буюу 21.2% нь шүүхийн тогтоол гүйцэтгэх хугацааны талаар мэдээлэл авдаг байна. Харин хорих, баривчлах болон цагдан хорих байршлын талаарх мэдээллийг 9 буюу 9.1% нь авдаг байна.

Хүснэгт 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдийн авч байсан мэдээлэл

Шүүхийн шийдвэр хэрэгжиж эхэлсэн байдал	30	30,3
Хорих, баривчлах болон цагдан хорих байрны байршил	9	9,1

Шүүхийн тогтоол гүйцэтгэх ажиллагааны хугацаа	21	21,2
Бусад	21	21,2

Асуулт 3. “Та цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг авч байсан давтамжаа тодорхойлно уу?”

Иргэн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас мэдээлэл авч байсан давтамжийг тодорхойлох нь мэдээлэл авах хэрэгцээ шаардлага нөгөө талаас дээрх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хэмжих шалгуур болно. Дээрх асуултанд судалгаанд оролцогчдын 69 буюу 69.7% нь 1-2 удаа, 15 буюу 15.2% нь 3-4 удаа, 8 буюу 8.1% нь 5-6 удаа, 5 буюу 5.1% нь 6-с дээш удаа мэдээлэл авч байсан гэж тус тус хариулжээ. Судалгааны дүнгээс үзвэл иргэдийн мэдээлэл авах хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулж байна.


Асуулт-4. Та цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрт хэрэгцээтэй мэдээ, мэдээллийг авахаар хүсэлт гаргахад ямар хариу өгч байсан бэ?


Хэрэгцээтэй мэдээллийг гарган өгч байсан гэж 33 буюу 33.3% нь, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцлал гэсэн шалтгаанаар мэдээлэл өгөөгүй гэж 13 буюу 13.1% нь, Прокурорын зөвшөөрсөн хэмжээнд гаргаж өгч байсан гэж 9 буюу 9.1% нь, хариу өгдөггүй гэж 15 буюу 15.2% нь, хариу өгсөн ч хэрэгцээтэй мэдээлэл байдаггүй гэж 26 буюу 26.3% нь тус тус хариулсан байна.

Судалгааны дүнгээс үзэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас авч буй мэдээлэл нь иргэдийн хэрэгцээг хангаж байгаа талаар харилцан адилгүй санал илэрхийлсэн байна. Энэ нь тухайн иргэн ямар төрлийн мэдээлэл шаардаж байгаагаас хамааран сэтгэл ханамжийн байдал өөр өөр гарч байна.

Тухайлбал, хуулиар хориглосон, хувь хүн, байгууллага, хэрэг, бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаатай холбоотой мэдээлэлийг шаардсан тохиолдолд мэдээлэл өгдөггүй бөгөөд зайлшгүй тохиолдолд нууцад хамаарахгүй мэдээллийг гаргаж өгдөг талаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид хэлж байна.

График 8. Иргэдийн хүсэлтэд өгсөн хариултын агуулга





Судалгаанд оролцогчдын 81 буюу 81.4% нь өөрийн гаргасан хүсэлтийн дагуу ямар нэгэн мэдээллийг авч чаддаг талаар санал илэрхийлсэн тус байгууллагын зүгээс иргэний хүсэлтийг хангаж ажилладаг гэж дүгнэж болохоор байна.

Асуулт 5. “Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл авах хэрэгцээ Танд хир их байдаг вэ?”

Иргэдийн мэдээлэл авах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор авсан дээрх асуултад судалгаанд оролцогчдын 81 буюу 81.4% нь өөрийн гаргасан хүсэлтийн дагуу ямар нэгэн мэдээллийг авч чаддаг гэж хариулжээ. Судалгааны дүнг хариулт тус бүрээр авч үзвэл маш их хэрэгцээтэй байдаг гэж 20 буюу 20.2% нь, хэрэгцээтэй гэж 60 буюу 60.6% нь, шаардлаггүй гэж 10 буюу 10.1% нь мэдэхгүй гэж 8.1% нь тус тус хариулсан байна.

Асуулгын дүнгээс үзвэл нийт судалгаанд оролцогчдын 80 буюу 80.2% нь мэдээлэл авах хэрэгцээтэй байдаг гэж хариулсан байна. Энэ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал хангалтгүй, иргэдэд ойлгомжгүй асуудал түгээмэл байгааг илэрхийлэх юм.

Асуулт-6. “Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай ямар мэдээлэл байдаг бэ?”

Судалгааны ажлын үндсэн зорилтын нэг нь шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын зүгээс иргэдэд нээлттэй болгох мэдээ, мэдээлэл, түүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох явдал байсан. Тиймээс судалгаанд оролцогчдоос **“Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай ямар мэдээлэл байдаг бэ?”** гэсэн асуултыг нээлттэй тавьж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат тус бүрээр тодорхой санал бичүүлж авсаныг хүснэгт 2-т нэгтэн харуулав.

Хүснэгт 3. Иргэдэд нээлттэй болгох шаардлагатай мэдээллийн жагсаалт

№	Байцаан шийтгэх ажиллагааны үе шат	Хариулт
1	Хэрэг бүртгэлт, мөрдөн	-Хэрэг хэзээ шийдэх талаар хэлдэггүй;

	байцаалтын шатанд	<ul style="list-style-type: none"> -Хохирогчийн талаар мэдээлэл өгдөггүй; -Хавтаст хэрэгтэй сайн танилцуулдаггүй; -Хэргийг шалган шийдвэрлэх явц байдал; -Өөрийн хэргийн талаар мэдээлэл авахад тааруу; -Хохирогч санал гомдолтой эсэх; -Хэргийг бүрэн эхээр нь хуулбарлаж авах боломжоор хангах; -Холбогдогч этгээдийн талаарх мэдээлэл; -Эрх, үүргийн талаар тодорхой ойлголт өгдөггүй; -Хэргийн газрын нөхцөл байдал; -Хэргийн талаар хангалттай хэлдэггүй, тодорхой бус байдаг; -Хэргийн талаар тодорхой мэдээлэл огт өгдөггүй -Хэргийн оролцогчдын талаарх мэдээлэл; -Хэргийн зүйлчлэл; -Ажиллагааны нууцлал гэсэн шалтгаанаар бүгд мэдээлэл өгөх дургүй, хүссэн мэдээллээ авахад хүндрэлтэй байдаг; -Хэргийн талаар мэдээлэл бага өгдөг, удаан хүлээлгэдэг; -Хэргийг шалгаж эхэлсэн үеэс мэдээлэл нээлттэй байвал зүгээр; -Бүрэн гүйцэд тайлбарлаж өгдөггүй; -Хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийн хохирогчид ээлтэй, нууцлалыг хангасан орчинд байцаалт өгөх боломжийн талаар мэдээлэл хүсэх, шаардлага тавихад хүлээж авдаггүй; -Тодорхой бус мэдээлэл өгдөг; - Шинжээчийн дүгнэлийг танилцуулдаггүй; -Ажиллагааны талаар гаргасан санал, хүсэлтийг хүлээн авдаггүй, миний ажлыг зааж байна гэх байдлаар ханддаг. Тухайлбал, гомдолын хугацаа болон шалгуулах асуудлаар гаргасан саналыг хэрхэн шийдсэн гэх мэт; -Оролцогчид танилцуулж болох мэдээллийг хүргэдэггүй. Харин өөрсдөө нууцлалыг задруулдаг: Тухайлбал, саналыг бусдад нь хэлж мэдээлэх гэх мэт; -Хавтаст хэрэгтэй танилцуулаагүй; -Хохирол учруулсан хүний мэдээлэл хэрэгтэй байдаг; -Гомдол, мэдээлэл аль шатанд, яаж шийдэгдэж байгааг мэдэх; -Хууль эрх зүйн мэдээллүүд хэрэгтэй байдаг; -Цаг үеийн нөхцөл байдал; -Хувийн хэрэгтэй танилцахад төвөгтэй байдаг.
2	Прокурорын хяналтын шатанд	<ul style="list-style-type: none"> -Хэзээ дуудахаа хэлдэггүй; -Мэдээлэл огт өгдөггүй, тухайлбал хэргийг хэзээ шүүхэд шилжүүлэх; -Хяналтын хугацаа; -Эцэслэн шийдвэрлэх хугацаа -Шүүхэд шилжүүлсэн эсэх; -Хэргийг бүрэн эхээр нь хуулбарлаж авах боломжоор хангах; -Нөгөө талаас гаргасан санал, гомдол; -Хувь хүний нууцтай холбоотой; -Өөрөө мэдээгүй байхад ял оноосон байдаг -Гомдол гаргах эрхийг минь хязгаарладаг; -Хэргийг хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн үндэслэл тодорхойгүй; -Хохирол барагдуулахгүй байгаа шалтгаан; -Хэргийн шийдвэрлэлтийн хугацаа

		<ul style="list-style-type: none"> -Хэрэг ямар шатанд шалгагдаж байгаа явц, үр дүн; -Гэрч, хохирогчийн мэдээлэл; -Прокурорт гаргасан гомдол, хүсэлт шийдвэрлэгдсэн эсэх; -Прокурорын ямар даалгавараар ажиллагаа хийж байгаа нь тодорхой байх; -Хэрэгт ач холбогдол бүхий мэдээллүүд.
3	Шүүх	<ul style="list-style-type: none"> -Хэргийн явц, оногдуулах ял; -Шүүх хуралдааны тов; -Хэргийн талаар тодорхой мэдээлэл огт өгдөггүй; -Ямар хүмүүс шүүх хуралд оролцох нь тодорхойгүй; -Ирц бүрдсэн эсэх талаарх мэдээлэл; -Шүүхийн шатанд шилжиж ирсэн хойно эрүүгийн хэргийн материалтай танилцахад нээлттэй байдаг ч хуулбарлаж авахад хүндрэлтэй байдаг; -Шүүхийн шийдвэр; -Хэргийн зүйлчлэлийн үндэслэл болон шийдвэрлэсэн нотолгооны талаар мэдээлэлд хариу өгдөггүй; -Шийдвэрлэх хугацаа.
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд	<ul style="list-style-type: none"> -Үйлчлүүлэгчийг хаана ямар хорих ангид шилжихийг хэлдэггүй; - Үйлчлүүлэгчид хаана, ямар газар, хэрхэн ял эдлүүлэх талаар мэдээлдэггүй; -Хэн гэдэг шийдвэр гүйцэтгэгч хариуцаж байгаа талаарх мэдээлэл; -Шийдвэр биелүүлэх хугацаа; -Шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгааны талаарх мэдээлэл; -Мэдээлэл авах гэж маш их хугацаа алддаг; -Тогтоол гүйцэтгэлийг хангах үйл явц болох нэхэмжлэлийг барагдуулах ажиллагааны талаар, хугацаа болон нуугдмал орлогын талаар асуусан асуудал; -Хохироосон хүний эд хөрөнгийн мэдээлэл; -Хохирлыг хэрхэн барагдуулах талаар; -Шийдвэрийн биелэлт ямар шатандаа яваа талаарх мэдээлэл; -Төлбөр төлөлтийн хугацааг оруулах; - Хорих, баривчлах болон цагдан хорих ангиас суллагдах хугацаа, он сар өдөр; -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурор, түүний байршил, болон бусад мэдээллийн талаар; -Албандан ажил хийлгэх ял гүйцэтгэх газар, хийх ажил, хугацаа - Хураагдсан эд хөрөнгө, хаана хэн гэдэг албан тушаалтны мэдэлд хадгалагдаж байгаа эсэх, хэрхэн буцааж авах; -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зохион байгуулдаг дуудлага худалдаа, эд зүйлсийн үнийн саналын талаар; -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явц, хугацааны талаар; -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дууссан талаарх мэдээлэл; -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоосон талаарх мэдээлэл; -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зардал, түүнийг

		<p>гаргуулах тухай;</p> <p>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гүйцэтгэгдсэн эсэх талаарх лавлагаа, тухайлбал эд хөрөнгө битүүмжилсэн г.м;</p> <p>-Хариуцагч, нэхэмжлэгч талын хувийн мэдээлэл, оршин суугаа газар, холбоо барих утас;</p> <p>-Шүүхээс оногдуулсан торгох ялыг төлж барагдуулах талаарх график;</p> <p>-Хорихоос суллагдсан тохиолдолд хэрхэн нийгэмших, нийгмийн халамж авах талаар;</p> <p>-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд өөрсдөө оролцох боломж нөхцөл байгаа талаар;</p> <p>-Хорих байгууллага, цагдан хорих ангид хүчлэн хамгаалалт авч байгаа талаар, түүний хугацааг ар гэрийхэн мэдэх боломжгүй;</p> <p>-Хорих ангид ажлын хоног хэрхэн боддог аргачлал, түүнийг ар гэрт нь мэдэгддэг эсэх;</p> <p>-Хорих анги, цагдан хорих ангид байгаа хүний эрүүл мэндийн талаар өөрт нь болон ар гэрийнхэнд нь мэдэгддэг байх;</p> <p>-Эмнэлэгт хэвтсэн талаар ар гэрт мэдээлэл өгдөггүй.</p>
--	--	---

Дээр дурдсан шаардлагатай гэж үзэж багаа мэдээлэл нь зарим тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалд хамаарах баримт мэдээлэл хамаарч байна. Зарим талаар иргэдэд нээлттэй хүргэж байгаа мэдээллийг хэрхэн хүсэлт гаргаж, хаанаас олж авах талаар тодорхой мэдээлэл байдаггүй бөгөөд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдаас нэхдэг хүндрэл учирч байна.

Түүнчлэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэргийн материалтай танилцах тодорхой эрх нь тухайн ажиллагаанд оролцогч субъект болон өмгөөлөгчид олгогдсон байдаг. Энэ нөхцөл байдлаас шалтгаалан гэр бүлийн гишүүд зарим тохиолдолд хэргийн материалтай танилцах хүсэлт гаргадаг боловч хүсэлтийг нь хангах боломж байдаггүй байна. Тухайлбал, хорих ангид ял эдэлж байгаа ялтан өөрийн талаарх мэдээллээ гэр бүлийнхэндээ өгдөггүй тохиолдол гардаг, нөгөө талаас алба хаагчид шаардлагатай мэдээллийг зөвхөн ялтанд өгдөг байна.

Асуулт-7. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх ямар мэдээ, мэдээллийг хувь хүн Танд нээлттэй болгох шаардлагатай гэж үзэж байна бэ?

Хүснэгт 4-т үзүүлснээр оролцогчдын хамгийн өндөр санал өгсөн мэдээлэл нь **цагдаагийн байгууллагын хувьд иргэд гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн мэдээлэл 91.3%, прокурорын байгууллагын хувьд хяналтын прокурорын шийдвэр 84.0%, шүүхийн байгууллагаас шүүхийн шийдвэр 98.4%, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шүүхийн шийдвэр хэрэгжисж эхэлсэн байдал 81.5%** гэж тус тус хариулсан байна.

Хүснэгт 4. Иргэнд нээлттэй болгох шаардлагатай мэдээлэл

№	Байгууллага	Шаардлагатай		Шаардлагагүй		Мэдэхгүй		Дүн
		тоо	(%)	тоо	(%)	тоо	(%)	
	Цагдаагийн байгууллагаас							
1.	Гомдол, мэдээлэл, хэргийг шалгаж буй алба хаагч	59	75.6	16	20.5	3	3.8	78
2.	Хэрэгсэхгүй болгох санал гаргасан байдал	54	75.0	13	18.0	5	6.9	72
3.	Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт	63	91.3	3	4.3	3	4.3	69
	Прокуророос							
4.	Эрүүгийн хэргийг хүлээн авсан огноо	50	73.5	12	17.6	6	8.8	68
5.	Эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй прокурорын нэр	51	75.0	10	14.7	7	10.2	68
6.	Хяналтын прокурорын шийдвэр	58	84.0	5	7.2	6	8.6	69
7.	Прокурорт яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар явуулсан санал, шийдвэр	54	81.8	8	12.1	4	6.0	66
8.	Гомдол хүсэлт гаргах журам, заавар	50	78.1	7	10.9	7	10.9	64
	Шүүхээс							
9.	Шүүх хүлээн авсан огноо	38	64.4	16	27.1	5	8.4	59
10.	Хянан шийдвэрлэх шүүгчийн нэр	47	72.3	13	20.0	5	7.6	65
11.	Шүүхийн шийдвэр	65	98.4	0	0.0	1	1.5	66
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас							
12.	Шүүхийн шийдвэр хэрэгжиж эхэлсэн байдал	53	81.5	5	7.6	7	10.7	65
13.	Давж заалдах гомдол гаргах хуулийн заалт	48	72.7	10	15.1	8	12.1	66
14.	Бусад	38	86.3	2	4.5	4	9.0	44

Судалгааны дүнгээс үзэхэд иргэд тухайн байгууллагаас гардаг **шийдвэрийн талаар мэдэхийг хамгийн их хүсдэг** байна. Гэвч дээрх байгууллагууд ямар нэгэн шийдвэр гаргахдаа заавал холбогдох хүмүүст мэддэг хуулийн болон зохион байгуулалтын зохицуулалттай байдаг. Гагцхүү гэр бүлийн гишүүд эсхүл тодорхой шийдвэр гарахын өмнө урьдчилсан байдлаар хэргийн явц байдлын талаар танилцахыг хүсч мэдээлэл хайдаг нөхцөл байдал дээрх хариултад мөн нөлөөлөх талтай.

Асуулт- 8. “Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх мэдээллийг Танд ямар арга замаар нээлттэй болговол зүйтэй вэ?”

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллаганд оролцогч болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаар үйлчлүүлэгчид хурдан шуурхай хүргэж байх нь мэдээллийн ил тод байдлын агуулгыг илэрхийлдэг. Тиймээс бид судалгаанд оролцогчид **“Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн**

шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх мэдээллийг Танд ямар арга замаар нээлттэй болговол зүйтэй вэ? гэсэн асуулт тавьж хариулт авсан болно.

Судалгаанд оролцгчдын **32 буюу 32.3% цахим шуудангийн хаягаар хүргүүлдэг байх, 47 буюу 47.5% нь тусгайлан цахим хуудсанд нэвтэрч, нэр, нууц үгээр ашиглан мэдээлэл авдаг байх, 35 буюу 35.4% нь гар утсанд захидал очдог байх, 11 буюу 11.1% нь амаар, 20 буюу 20.2% нь бичгээр, 1 буюу 1% нь бусад хэлбэрээр гэж тус тус хариулсан байна. Дүнг “хүснэгт 5”-т үзэх.**

Хүснэгт 5. Мэдээлэл нээлттэй болгох хэлбэр

1	Цахим шуудангийн (мэйл) хаягаар хүргүүлдэг байх	22	10	0	32
2	Тусгайлан сайтад нэвтэрч, нэр, нууц үгээр ашиглан мэдээлэл авдаг байх	33	8	6	47
3	Гар утсанд захидал очдог байх	20	11	4	35
4	Амаар	3	7	1	11
5	Бичгээр	14	6	0	20
6	Бусад	0	1	0	1

Судалгаанд оролцогчдын хариултыг нэгтгэн үзвэл өөртэй нь холбогдсон мэдээлэл, хүсэлт, гомдлын хариуг аль болох амаар авах хэлбэрээс татгалзах хандлагатай байгаа бол цахим сүлжээ ашиглан шаардлагатай мэдээлэл, өргөдөл гомдлын хариу авах боломжийг бүрдүүлэхийг хүсч байна. Судалгааны явцад гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг цахим сүлжээ ашиглан иргэдэд хүргэж байгаа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага байгаа эсэх талаар судалгаа хийж үзсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЦАХИМ САН

Нийт 53148 хэргийн 69881 шийдвэр байна.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРҮҮД

- Эрүүгийн хэрэг
- Иргэний хэрэг
- Захиргааны хэрэг
- 2013 оны 12 дугаар сарын 18-наас өмнөх шийдвэрүүд
- 2015 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хойших шийдвэрүүд

Холбоо барих

Хаяг: Шүүхийн ерөнхий зөвлөл
Тасганы овоо,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот,
Монгол Улс,
Зип - 15170

Утас: 70008045

Факс: 70007021

Веб сайт: www.judcouncil.mn

И-мэйл: contact@judcouncil.mn


ШҮҮХ ХУРАЛДААНЫ ЗАР, ТОЙМ

- Шүүх хуралдааны зар
- Шүүх хуралдааны тойм
- Шүүх хуралдааны бичлэг

Монгол Улсын анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийг олон нийтэд ил тод болгосон, мөн шүүх хуралдааны товч, зар мэдээллийг иргэдэд нээлттэй байдлаар хүргэсэн <http://www.shuukh.mn> цахим хуудас ажиллаж байна. Уг сайтад өнөөгийн байдлаар 53148 хэргийн 69881 шийдвэр байна. Уг сайтад эрүүгийн хэргийн шүүхийн тогтоолуудыг байршуулсанаас хэргийн эцсийн шийдвэрлэлтийг харах боломж бүрджээ. Харин шүүхэд “иргэн-2014” гэсэн програмыг ашигладаг бөгөөд иргэний хэрэг, маргаан нь аль шатны шүүх дээр ямар шатанд байгаа талаарх мэдээллийг иргэд авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагад <http://www.service.police.gov.mn/> цахим хуудас 2015 оны 08-р сараас эхлэн ажиллуулж байна. Цагдаагийн байгууллагад хандаж иргэдээс амаар, бичгээр,

утсаар, цахимаар гаргасан өргөдөл, гомдлыг аль газар, хэлтэс, нэгжийн ямар албан тушаалтан шалгаж, ямар шийдвэр гаргасан талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй болгожээ. Ингэхдээ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 202 код журамд заасны дагуу “Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авсан тухай тэмдэглэл”-г хөтөлж, иргэдэд бүртгэлийн дугаар бүхий хяналтын хуудас өгдөг байна. Өргөдөл, гомдол гаргасан иргэн нь бүртгэлийн дугаар, регистрийн дугаараараа <http://www.service.police.gov.mn/> бүртгүүлж, шийдвэрлэлтийг харах боломжийг бүрдүүлжээ.




Ингэснээр цагдаагийн байгууллага болон алба хаагчтай холбоотой мэдээ мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол өгөх, бүртгүүлсэн эрхээрээ нэвтрэн орж өгсөн өргөдөл, гомдлын явц болон шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл, тэмдэглэл зэргийг дэлгэрэнгүйгээр хүлээн авах боломжтой болжээ.

Асуулт-9 “Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг та хэрхэн үнэлэх вэ?”

Мэдээллийн ил тод байдлыг хэмжих өөр нэг аргачлал нь шүүх, хууль сахиулах байгууллагуудад мэдээллийн и тод байдлын талаарх иргэдийн хандлага юм. Учир нь мэдээлэл ил тод байх нь иргэдийн хандлагад эерэгээр нөөлдөг бол мэдээлэл хааалттай байх нь сөргөөр нөлөөлдөг гэж үздэг.

Тиймээс гэсэн асуултыг оролцогчидод тавьж үр дүнг байгууллага тус бүрээр гаргав. “График 9”-д үзүүлснээр цагдаагийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж судалгаанд оролцогчдын 44.7% нь үзсэн бол прокурорын байгууллагын мэдээллийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж 39.8%, шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж 49.4% нь, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдалд маш сайн буюу сайн гэж 36.5% нь тус тус үнэлсэн байна.

График 9. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлын талаарх иргэдийн төсөөлөл



Судалгаанд оролцогчдын 55.3% нь цагдаад, **60.2% нь прокурорт**, 50.6% нь шүүхэд, **63.5 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх** байгууллагад дунд-муу-маш муу гэсэн үнэлгээг сонгож үнэлсэн байна.

Судалгааны дүнгээс үзвэл, иргэд шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр гэж дүгнэсэн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангалтгүй гэж үзсэн байна. Цагдаагийн болон прокурорын багууллагын мэдээллийн ил тод байдал дундаж түвшинд байна.


Түүнчлэн, **иргэд байгууллагын мэдээллийн ил тод байдлыг үнэлэхдээ алба хаагчдын харилцааны соёл, хандлагаар** дүгнэдэг. АНУ-ын Мичиганы Их сургуулийн социологийн тэнхимээс 2012 онд 4000 иргэний дунд явуулсан “нийгмийн үнэт зүйлсийн судалгаа”-ны үр дүнгээр төрийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ур чадвар нь иргэдийн мэдээлэл олж авах эрхэд шууд нөлөөлдөг гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, харилцааны соёл ур чадвар муутай алба хаагчидтай байгууллагаас мэдээлэл авахад хүндрэлтэй, хаалттай байдаг гэж үзжээ (Hwang 2014).

Энэ дүгнэлтийг шалгах зорилгоор хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ур чадварын талаарх иргэдийн хандлагыг тодорхойлох оролдлого хийсэн. Судалгаанд оролцогчдоос “**Дараах байгууллагуудын алба хаагчдын иргэдтэй харилцах хандлага, төлөвшлийг та хэрхэн үнэлэх вэ?**” гэсэн асуулт тавиад хариултыг байгууллага тус бүрээр нь гаргаж, өмнөх асуулгын үр дүнтэй харьцуулан дүгнэлт хийсэн болно.

“График 10”-т үзүүлснээр шүүхийн алба хаагчдын харилцааны соёл, хандалгад судалгаанд оролцогчдын 59.2% нь сайн буюу маш сайн гэсэн үнэлэлт өгсөн нь бусад байгууллагын алба хаагчтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байсан бол муу буюу маш муу гэж 8.5% нь үнэлсэн нь мөн хамгийн бага үзүүлэлт болж байна. **Түүнчлэн, иргэдийн 52.2% нь цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, төлөвшлийг маш сайн буюу сайн гэж дүгнэсэн бол энэ үзүүлэлт прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд 50 хувьд хүрэхгүй байна.**

График 10. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын харилцааны соёл, хандлага

■ сайн буюу маш сайн ■ дунд ■ муу буюу маш муу




Дээрх судалгааны дүнгээс үзвэл иргэд шүүх, цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, төлөвшил, мэдээллийн ил тод байдал бусад байгууллагатай харьцуулахад өндөр байгаа нь Мичиганы их сургуулийн эрдэмтдийн дүгнэлтийг баталж байна. Түүнчлэн, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, алба хаагчдын харицааны соёл, төлөвшлийн талаарх иргэдийн хандлагын судалгааны үр дүнгийн үнэлгээ дээрх 2 асуултын хувьд ижилхэн гарч байгаа нь прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээрх асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

2.3 Өмгөөлөгч нарын дунд ярилцлагын аргаар явуулсан судалгааны үр дүн

Судалганы ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилтын нэг нь “Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдал, иргэдэд нээлттэй болгох мэдээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үүднээс өмгөөлөгч нарын дунд ярилцлагын аргаар судалгаа явуулж дүгнэлт хийх” ажил багтаж байсан. Тиймээс энэхүү судалгааг 57 өмгөөлөгчид урьдчилан бэлтгэсэн 5 асуулт, 1 нээлттэй асуулт тавьж ярилцлагын аргаар судалгааг явуулж тоймлон тайланд тусгав.

Тайлбар: Судалгааны тайлангийн практик хэрэглээнд чухал ач холбогдолтой учраас өмгөөлөгчдөөс гаргасан санал, бодол, шүүмжлэл, хүсэлтийг нэг бүрчлэн судалгааны тайланд хавсралтаар оруулсан болно.



Асуулт-1. Таны өмгөөлөгчөөр ажилласан жил, Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагатай хир удаан холбогдон ажиллаж байна?

Судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 12 буюу 21.3% нь 1-3 жил, 11 буюу 19.6% нь 4-6 жил, 6 буюу 10.7% нь 7-10 жил, 27 буюу 48.2% нь 10-с дээш жил өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлсэн байна. Энэхүү ажилласан жилийн туршлага нь бидний судалгааны ажлын зорилтыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ гэж дүгнэж байна.

Асуулт-2. Өмгөөллийн үйл ажиллагаа явуулахад цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас ямар төрлийн мэдээллүүд танд илүү хэрэгтэй болдог вэ?

1. Цагдаагаас: Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээлэл, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явц, хугацааны талаарх мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулж байгаа, хэргийн шалгалтын явц байдал, сэжигтнээр татсан, хорьсон, баривчилсан үндэслэл, нотлох баримт, сэжигтнийг ямар үндэслэлээр буруутган шалгаж байгаа, түүний гэм буруутайг нотлох баримт болон шинээр илэрсэн нотлох баримтын талаарх мэдээлэл, ЭБШХ-д заасан нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно гэсэн заалтын дагуу уг хэрэгт өөр өмгөөлөгч давхар ажиллаж байгаа талаарх мэдээлэл, хэрэгт хэдэн хүн холбогдсон, үйлчлүүлэгчийн оролцоо, мөрдөн байцаалтын ажиллагаа ямар шатанд байгаа талаар, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, прокурорын хяналт, шүүхийн шатанд шилжүүлсэн тухай мэдээлэл, ерөнхийдөө **“Нууцын тухай” хуульд тогтоосноос бусад мэдээллийг өгөх** хэрэгтэй болдог гэжээ.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага: Төлбөр төлөгчөөс төлбөр барагдуулах талаар удаашралтай хэргийн үндэслэл, шалтгаан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан ямар ажиллагаа гүйцэтгэсэн болох, төлбөр төлөгчийн эд хөрөнгийг эрэн сурвалжилсан эсэх талаарх мэдээллүүд. Эд хөрөнгө үнэлж буй шинжээчийг ямар журмын дагуу томилдог талаарх мэдээлэл, мөн эд хөрөнгө хураан авах, битүүмжлэх ажиллагааны тов, цагдан хорих ангид хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчийн эрүүл мэндийн байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хорих ангийн ажиллах журам, уулзалтын журам, байршил, албадан ажил хийлгэх бол хэдэн цагийн, ямар үнэлгээтэй ажил хийх талаарх мэдээлэл.

3. Прокурорын байгууллагаас: Прокурорын даалгаварт ямар ажиллагаа гүйцэтгүүлэх талаар тусгагдсан мэдээллүүд, хэргийн материалд прокурорын даалгаврыг оруулдаг болох. Прокурорын үйл ажиллагаа хэт нэг талыг барьсан яллах чиг үүргээ давамгайл хэрэгжүүлж байгаагаас таслан сэргийлэх арга хэмжээг (цагдан хорих) өөрчлөх, хугацаа сунгах зэрэг асуудлыг дангаараа шүүхэд хандан шийдвэрлүүлэх нь байсаар байгаа. Хэдийгээр өмгөөлөгчийн зүгээс хүсэлт гаргадаг ч тухайн асуудлыг шийдвэрлэх хуралд оролцуулдаггүй, шүүхээс хурлын тов зэрэг мэдээлэл өгдөггүй хаалттай байдлыг зогсоох, тодорхой ажиллагаа явуулах газар, байршлын талаарх мэдээлэл, хэргийн хугацаа сунгасан, цагдан хорих хугацаа сунгасан эсэх, гэмт хэргийн нийт үйлдэл, хохирол, хувийн байдал судалсан баримт зэрэг мэдээлэл, хэдийгээр тухайн байгууллагын дотоодод мөрддөг дүрэм журам боловч үйл ажиллагаанд баримтлах заавар, журам¹, мөн тухайн байгууллага тус бүрийн ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм, үйл ажиллагааны стандарт² зэрэг баримт бичгүүд зэргийг нийтэд ил тод болгох.

4. Шүүхээс: Тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх хугацааны талаарх мэдээллүүд, тухайн хэргийг шалгаж буй шүүгчийн хувийн байдлын талаарх мэдээллүүд, тодорхой төрлийн хэрэг ямар үндэслэлээр шүүхийн шатнаас буцаж байгаа талаар шүүхээс хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нарт мэдээлэл өгдөг байх, шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээллүүд, статистик, шийдвэрлэсэн болон хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо, хэрэгсэхгүй болгосон болон нэмэлт мөрдөн байцаалтад буцааж буй шалтгаан зэргийг тоймлон мэдээллэж байх, мөн байгууллагын бүтэц, хэлтэс тасгуудын чиг үүрэг, гомдол, хүсэлт хүлээж авч шийдвэрлэх ахлах, удирдах албан тушаалтнууд нь ямар цол, эрэмбэтэй, хэн болох талаарх мэдээлэл, цаг тухайд нь таслан сэргийлэх арга хэмжээний хурлын товыг хүсэлт гаргасан өмгөөлөгчид нэн даруй, нээлттэй мэдээллэдэг байх.

¹ Прокурорын байгууллагад хэрэглэгддэг Хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих аргачилсан заавар

²Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагааны стандарт

Асуулт-3. Гэмт хэрэгт холбогдсон, хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас ямар мэдээ, мэдээллийг нээлттэй байдлаар хүргэдэг вэ?

1. **Статистик мэдээллийг нээлттэй хүрэгэдэг.** Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Дээд шүүх, Цагдаагийн ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын газраас мэдээлэл хүргүүлдэг. Энэхүү мэдээлэл нь зөвхөн гэмт хэрэгт холбогдсон иргэдийн статистик мэдээлэл гардаг бөгөөд гэмт хэгийн улмаас хохирсон иргэдийн эрх ашгийг хэрхэн хамгаалсан талаарх мэдээлэл гардаггүй;

2. **Цагдаагаас:** Сэжигтэн, яллагдагч болон хохирогч нарын талаарх мэдээлэл харьцангуй бага өгдөг, хэргийн материалтай танилцах хугацаа бага, харин прокурор, шүүхээс илүү олж мэддэг. Иргэдэд нээлттэй хүргэдэг мэдээллүүд хангалтгүй. Гэмт хэргээс урдчилан сэргийлэх талаарх мэдээллийг телевиз болон бусад мэдээллийн хэрэгслээр явуулдаг ч энэ нь зорилгодоо төдийлөн хүрдэггүй. Хэрэгт холбогдсон иргэдийн эрх ашигтай холбоотой мэдээлэл үндсэндээ маш хангалтгүй, гэмт хэрэгт холбогдсон хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор тэдний ар гэр найз нөхдийн мэдээллийг нээлттэйгээр хүргэдэг.

3. **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага:** Хэргийн холбогдогч нар нь цагдан хоригдож байх үедээ хүндээр өвчилсөн бол таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилсөн талаар мэдэгддэг байх.

4. **Прокурорын байгууллагаас:** Иргэдэд чиглэсэн мэдээлэл хангалттай биш.

5. **Шүүхээс: “Shuukh.mn”** цахим хуудсанд шүүхийн шийдвэрийг байршуулдаг. Эрх ашгаа хамгаалах, хууль тогтоомжид заасан эрх, үүргийг тайлбарлах шаардлагатай; Эрүүгийн хэрэг шүүхийн шатанд байх үед сэжигтэн, яллагдагч нартай уулзах цаг хугацаа болон шүүх хурлын товыг мэдээлдэг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар цугларсан нотлох баримтыг прокурорын шатанд мэдэгдэх бөгөөд эд мөрийн баримт, хохирол нөхөн төлүүлэлтийг нээлттэй байдлаар хүргэдэг. Шүүхээс иргэдэд нээлттэй мэдээлэл хүргэх нь бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй дэвшилттэй, шуурхай байгаа ч ихэнхдээ шийдвэрлэгдсэн хэргийн талаар мэдээлэл өгөхөөс хэтэрдэггүй. Иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг зөрчлөөс урдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээллүүд төдийлөн хангалтгүй.

Асуулт-4. Эрүүгийн байцаан шийтгэх болон шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэх ажиллагааны явцад оролцогчид болон түүний гэр бүлийн гишүүдээс ямар мэдээ, мэдээллийн талаар илүү их хүсдэг вэ?

1. Хуулиар хориглоогүй бусад төрлийн мэдээ мэдээллийг ил болгож хүсэлт гарган авах хүсэлтэй иргэдэд түргэн шуурхай гарган өгч байх, хуулийн зөвлөгөө, дүгнэлт, гаргалгаа, цаашид хэрхэх, сэжиглэгдсэнээс эхлээд хоригдох, суллагдах хүртэлх бүхий л процесс, хуулийн байгууллагын мэдээ, мэдээлэл, дүрэм, байцаан шийтгэх ажиллагаа хэрхэн явагдаж байгаа талаар, хохирлыг барагдуулах хугацаа, шалгаж байгаа мөрдөн байцаагчийн талаар болон ийм төрлийн гэмт хэрэг холбогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээлэл;

2. Хохирсон иргэдийн тухайд хэргийг үнэн бодитой шалгаж шийдвэрлэсэн эсэхэд эргэлзээ төрдөг учраас энэ төрлийн мэдээлэл авахыг илүү хүсдэг. Харин гэмт хэрэгт холбогдсон иргэний тухайд ямар арга замаар ялаас чөлөөлөгдөх, хөнгөн ял шийтгэгдэх талаар мэдээлэл;

3. Хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах, хохирол барагдуулах үндэслэл, боломж, гэрч болон бусад оролцогчийн хувьд гомдол, мэдээлэл, хэргийг шалгаж буй алба хаагч, хугацаа, гаргасан саналд хангалттай хариу өгөхгүй байгаа үндэслэл, шийдвэрлэлт.

Асуулт-5. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас гомдол, мэдээлэл, хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийн талаарх ямар мэдээллийг иргэдэд ил тод болгох боломжтой гэж Та үздэг бэ?

1. **Цагдаагаас:** Мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч хавтаст хэрэгтэй танилцах боломжтой байх, хуулиар хориглосноос бусад төрлийн мэдээ, мэдээлэл, явцын талаарх мэдээлэл, гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ, мэдээллийг шүүх хуралдааны дараа мэдэгддэг байх, сэжигтэн, яллагдагч нарын ар гэрээс гаргасан санал, хүсэлтийг мэдээлдэг байх, мөрдөн байцаагч нар цаг хугацаа алдаж хэрэгт холбогдолтой мэдээ, мэдээллийг дамжуулж байна. Хэргийг шалгах явцад тулгамдсан асуудал болон хохирлын хэмжээ мөрдөн байцаалтын ажиллагааны явцад яаралтай төлөх талаар мэдээлэл өгөх ёстой. Мөн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу гэмт хэрэг илрүүлэх, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн ар гэртэй уулзалт зохион байгуулж тодорхой мэдээлэл өгдөг байх, гомдол, мэдээлэл хэрэг, зөрчлийн талаар хуулийн хугацаанд шалгаж дуусаад хариу мэдэгдэх хуудсыг дэлгэрэнгүй хүргэж байх, цаашид хийгдэх ажиллагааг товчхон мэдээлдэг болох, хэргийг шалгах хугацаа болон ямар шатанд байгаа, тухайн шатанд хэд хонож байгаа, хугацаа сунгагдсан зэрэг мэдээллийг цахим хэлбэрээр нээлттэй болгох хэрэгтэй.

2. **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага:** цагдан хоригдож байгаа сэжигтэн яллагдагчийн санал, хүсэлт, эрүүл мэндийн байдлыг нь танилцуулж хэвших, иргэдэд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэдэн жилийн ял шийтгэгдэж байгаа гэдгийг таньж мэдүүлдэг байх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэхгүй байх, удаашрах, дуудлага худалдаанд оруулах талаар гомдол гаргаж хугацаа хаах ажиллагааны талаарх мэдээлэл.

3. **Шүүхээс:** Гомдол, мэдээлэл хэрэг, зөрчлийн талаар хуулийн хугацаанд шалгаж дуусаад хариу мэдэгдэх хуудсыг дэлгэрэнгүй хүргэж байх, цаашид хийгдэх ажиллагааг товчхон мэдээлдэг болох, иргэдэд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэдэн жилийн ял шийтгэгдэж байгаа гэдгийг таньж мэдүүлэх. Өсөх хандлагатай байгаа хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл болон түүний шалтгаан, нөхцлийг тодорхойлох, энэ талаар урдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллийг цагдаа, шүүх, прокурорын байгууллагууд аль аль нь өгч байх нь зүйтэй.

Асуулт 6. Нэмэлт санал:

1. Шүүхийн шийтгэх тогтоолууд хууль зүйн хангалттай үндэслэл бүхий, эргэлзээгүй, нэг мөр ойлгомжтой гарч чаддаггүй. Энэ нь шүүгчдийн мэргэжлийн чадвартай холбоотой байх, яагаад гэмт хэрэг гэж үзэж ял шийтгэж байгаа нь гаргалгаа муутай хэт ерөнхий байдаг. Бас шүүгчид шийдвэрлэх гэж байгаа хэргээ сайн уншиж, судалдаггүй, гол гол баримтыг нь олоод уншдаг байж болох ч энэ нь хангалтгүй, зарим тохиолдолд харалган шийддэг;

2. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүх хуралдаанд сэжигтэн, яллагдагч, тэдний өмгөөлөгчийг байлцуулан, хорьж байгаа үндэслэл дээр хариу тайлбар өгөх боломжийг олгох;

3. Иргэдтэй харилцах харьцаанд анхаарах, соёлтой байх, албан хаагчдын тоог нэмэх, ачааллыг багасгах, түргэн шуурхай байх, орчин үеийн техник тоног төхөөрөмжийг ашиглаж сурах, цахим хаягаар харилцах;

4. Гомдол, эрүүгийн хэргийг хэрхэн шалгаж шийдвэрлэж байгаа, хуулийн хугацаанд шийдвэрлэж байгаа эсэх, ямар шатанд, ямар байгууллагын хяналтанд байгаа талаарх мэдээллийг цахим орчноос харах боломжоор хангавал өмгөөлөгчийн оролцоо илүү үр дүнтэй байх болно;

5. Цагдаагийн байгууллага хавтаст хэрэгтэй танилцахад цаг хугацаа гаргаж өгмөөр байна. бүрэн танилцаагүй байхад прокурор хаалаа, цаг нь амжихгүй боллоо гэж хэлээд хэргээ аваад яваад өгдөг;

6. Мэдээ мэдээллийг хуулийн дагуу хэвлэл мэдээллээр болон өмгөөлөгч нарт адил тэгш мэдээлдэг болмоор байна. Онд хүнд хэргийн талаарх мэдээ мэдээллийг хэргийн гэрч,

хохирогч нарт хамаагүй мэдээлэхгүйгээр шүүх хуралдааны үеэр дэлгэдэг болмоор байна. Одоо цагдаагийн байгууллага онц хүнд хэргийн нотлох баримтыг гэрч, хохирогч нарт мэдээлээд байна. Би үүний эсрэг талд нь зогсдог;

7. Хөнгөн гэмт хэрэгт өмгөөллийн үйл ажиллагааг ихэвчлэн явуулдаггүй. Хүмүүс өөрсдийн хайхрамжгүйгээс болоод хөнгөн гэмт хэрэгт ял шийтгэгддэг. Хуульчдын хорооноос өмгөөллийн үйл ажиллагааны талаар сурталчилмаар байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цагдан хорихтой холбогдсон мэдээллийг ил тод болгомоор байна. Ерөнхийдөө энэ байгууллагаас тодорхой мэдээлэл авч байсан удаа байхгүй;

8. Шүүхийн шатанд хэрэг шилжих үед эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нар хэрэг аль шүүх рүү шилжсэн болох, хэрэгт шаардлагатай байцаалт хэн өгөөгүй эсэхийг мэддэггүй. Шүүх үйл ажиллагаагаа нээлттэй болгож оролцогч нарт цаг алдалгүй мэдээлдэг болох;

9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага сэжигтэн яллагдагч нарын ар гэрт холбогдох мэдээллийг хурдан шуурхай дамжуулдаг болмоор байна. Тухайлбал цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч хэзээ суллагдсан, эрүүл мэндийн байдал зэргийг мэдээлдэг болмоор байна;

10. Мөрдөн байцаалтын ажиллагаанд хэргийг шуурхай шалгадаг арга тактикт шилжих шаардлагатай байна. Хангалттай нотлох баримт цугларсан байхад үл ялих зүйлээр шалтгалан хэргийг прокурор, шүүхийн шатнаас буцааж байна. Энэ явдлаас болж үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхол хөндөгдөж байна;

11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хорих ангиудын хаяг байршил, хоригдогчтой уулзах эргэлтийн цагийн талаарх мэдээллийг нээлттэй болгомоор байна. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын харьцааны соёл харьцангуй сайжирсан ч хэрэг мөрдөн шалгах арга барил нь хоцрогдож байна;

12. Гомдол, мэдээллийг ил тод болгоод зогсохгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессийг цахимаар харах боломжтой байх хэрэгтэй. Жишээ нь, мөрдөн байцаагч нь энэ 7 хоногтоо шилжүүлнэ гэсэн ч 3-4 долоо хоног болдог явдал байна. Мөн хэрэг харьяаллын дагуу шилжүүлсэн гэж мөрдөн байцаагч, прокурор хэлээд хэргийг түдгэлзүүлээд хав дарсан тохиолдолд ч гарсан. Тэгэхээр хэргийг шалгах ажиллагаа ямар үе шатанд, хэн гэдэг албан тушаалтанд байгааг цахимаар хардаг байх шаардлагатай;

13. Хүсэлт, гомдол хүлээн авч шийдвэрлэх албан тушаалтанг тодорхой болгох, түүний шийдвэрт гомдол гаргах, давж заалдах, хянуулах боломж, уг ажиллагааны хугацааны талаарх мэдээлэл иргэдэд ил байх;

14. Иргэдээс цагдаагийн байгууллагад хандан гаргасан гэмт хэргийн талаарх гомдлыг хүлээн авч холбогдох ажиллагаа хийх, зохих шалгалтын ажиллагаа явуулахаас цааргалах, хойрго хөшүүн хандах, огт шалгалт явуулахгүйгээр гомдол мэдээлэл хүлээн авдаг ажилтан тухайн асуудлыг эрүүгийн хэрэг үүсгэн шалгах эсэхийг “дур мэдэн” шийдвэрлэх тохиолдол бүх хэлтэс, газарт маш түгээмэл болсон (Асуулгад хамааралтай эсэхийг мэдэхүй байна);

15. Цагдаа, шүүх, прокурор зэрэг байгууллага өөрсдийн албан ёсны цахим хуудастай байдаг ч өөрт ач холбогдолтой зарим мэдээллийг олж авч чаддаггүй. Тухайлбал, өргөдөл, гомдол хүлээн авагч болон туслахын утасны дугаар, албан тушаал, зэрэг дэв, цол зэрэг мэдээлэл хаалттай байдаг. Түүнчлэн, албан хэрэгцээндээ ашигладаг дүрэм, журам, аргачилсан зааврууд зэргийг олж харах боломж хомс. Ер нь байршуулдаггүй.

Иймээс дээрх мэдээллийг нээлттэй байршуулах нь зүйтэй гэж үзэж байна. Зарим тохиолдолд цагдаа, прокурор, шийдвэр гүйцэтгэгч нарын утасны дугаарыг жижүүрээс асуухад **“хэлж өгөхгүй, боломжгүй эсхүл заавал өөрийн биеэр ирж авах”** талаар шаардлага тавьдаг зэрэг нь хүндрэл учруулж чирэгдэлтэй санагддаг. Мөн шинээр томилогдсон дарга, албан хаагчдын талаарх мэдээллийг шинэчилж оруулж байх шаардлагатай санагддаг. Ялангуяа цагдаа,

прокурорын томилгоо ойр ойрхон солигддогтой холбоотой. Байгууллагууд цахим хуудасныхаа мэдээллийг шинэчилж, агуулга сайтай болгох шаардлагатай;

16. Мэдээ мэдээлэл нээлттэй байх нь зөв ч хэн нэг хүний хувийн асуудлыг хэн дуртай нь орж үзэх зохимжгүй гэж бодож байна. Зохицуулалт байх хэрэгтэй;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ДҮГНЭЛТ

1. Мэдээлэл авах эрх зүйн зохицуулалт бүрдсэн бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэргийн өөрт холбогдох мэдээллийг авах эрхтэй байдаг бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дуусмагц хэргийн материалтай бүхэлд нь танилцуулах үүрэгтэй байна.

2. Иргэд гэмт хэрэг, зөрчилд хобогдсон гэсэн шалтгаанаар хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагатай хамгийн их холбогддог байна. Иргэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл хамгийн ихээр авдаг бол гомдол, мэдээлэл шалгаж буй алба хаагчдын талаарх мэдээлэл, хэрэгсэхгүй болгосон санал гаргасан байдал, байцаан шийтгэх ажиллагааны явц байдлын талаар мөн мэдээлэл авдаг байна.

Харин эрүүгийн хэрэгт хамааралтай бусад хүмүүсийн талаарх мэдээлэл авдаг гэсэн хариулт хамгийн бага буюу нийт оролцогчдын 5 хувь нь хариулж байгаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад зөвхөн өөртэй нь холбоотой мэдээллийг танилцуулдагтай холбоотой. Мөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын зүгээс хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хувийн байдалтай холбоотой мэдээлэл авах сонирхол ихтэй байдаг байна. Тухайлбал гэрийн хаяг, төрсөн газар, найз нөхөд гэх мэт.

3. Судалгаанд оролцогчдын 69 буюу 69.7 хувь нь 1-2 удаа, 15 буюу 15.2 хувь нь 3-4 удаа, 8 буюу 8.1 хувь нь 5-6 удаа, 5 буюу 5.1 хувь нь 6-аас дээш удаа мэдээлэл авч байсан гэж тус тус хариулж байгаа нь **иргэдийн мэдээлэл авах хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулж байна.**

Харин хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас авч буй мэдээлэлийн нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа талаар харилцан адилгүй санал илэрхийлсэн байна. Энэ нь тухайн иргэн ямар төрлийн мэдээлэл шаардаж байгаагаас хамааран сэтгэл ханамжийн байдал өөр өөр гарч байна.

4. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай мэдээлэл маш их байдаг талаар судалгаанд оролцогчид санал илрэхийлж банья. ялангуяа ар гэрийнхэний хувьд мэдээлэл маш хаалттай байдаг гэж дүгнэж байна.

5. Судалгаанд оролцогчдын хариултыг нэгтгэн үзвэл өөртэй нь холбогдсон мэдээлэл, хүсэлт, гомдлын хариуг аль болох амаар авах хэлбэрээс татгалзах хандлагатай байгаа бол **цахим сүлжээ ашиглан шаардлагатай мэдээлэл, өргөдөл гомдлын хариу авах боломжийг бүрдүүлэхийг хүсч** байна.

6. Судалгаанд оролцогчдын 55.3% нь цагдаад, 60.2% нь прокурорт, 50.6% нь шүүхэд, 63.5 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, дунджаар 57.5% нь хуулийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд дунд-муу-маш муу гэсэн үнэлгээг сонгож үнэлсэн байна. Судалгааны дүнгээс үзвэл, иргэд шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр гэж дүгнэсэн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангалтгүй гэж үзсэн байна. Цагдаагийн болон прокурорын багууллагын мэдээллийн ил тод байдал дундаж түвшинд байгаа бөгөөд тус байгууллагуудын алба хаагчдын харилцааны соёл, ур чадвар нь иргэдийн мэдээлэл олж авах эрхэд шууд нөлөөлж байна.

7. Шүүхийн ажилтнуудын харилцааны соёл, хандалгад судалгаанд оролцогчдын **59.2%** нь сайн буюу маш сайн гэсэн үнэлэлт өгсөн нь бусад байгууллагын алба хаагчтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байсан бол муу буюу маш муу гэж 8.5% нь үнэлсэн нь мөн хамгийн бага үзүүлэлт болж байна.

Түүнчлэн, иргэдийн **52.2%** нь цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, төлөвшлийг маш сайн буюу сайн гэж дүгнэсэн бол энэ үзүүлэлт **прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд 50 хувьд хүрэхгүй байна**. Эдгээр судалгааны үр дүнгээс үзвэл иргэд шүүх, цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, төлөвшил, мэдээллийн ил тод байдал бусад байгууллагатай харьцуулахад өндөр байгаа нь Мичиганы их сургуулийн эрдэмтдийн дүгнэлтийг баталж байна. Түүнчлэн, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, алба хаагчдын харицааны соёл, төлөвшлийн талаарх иргэдийн хандлагын судалгааны үр дүнгийн үнэлгээ дээрх 2 асуултын хувьд ижилхэн гарч байгаа нь **прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээрх асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна**.

8. Өмгөөлөгч нарын зүгээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд холбогдох төрийн нууцад хамаарахгүй мэдээ, мэдээллийг ил болгох нь зүйтэй гэдэг дээр санал нэгдэж байна. өмгөөлөгчдын илэрхийлсэн саналыг ерөнхий д нь дүгнэвэл мэдээлэл авахад хүндрэлтэй хаалттай байдаг гэж үзжээ. Өмгөөлөгч болон иргэдийн зүгээс нээлттэй болгохыг хүсч байгаа мэдээллийг хавсралтад бүрэн эхээр нь тусгав.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллаганы үе шатууд дахь хугацаа, түүнийг сунгах, тухайн шатнаас гарах шийдвэрийг танилцуулах ажиллагааг мөрдлөгө болгох.

2. Байцаан шийтгэх ажиллагааны явцад гарсан цагдаагийн санал, шийдвэр, прокурорын шийдвэр, шүүхийн шийдвэр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хугацаа зэргийг иргэдэд нээлттэй болгох.

3. Тодорхой шийдвэрийг гар утсанд захиагаар очдог систем, гэр бүлийн гишүүдэд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явц байдлыг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтнаас хамааралгүй танилцдаг цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх.

4. Хөдөө орон нутаг дахь байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг холбогдох мэдээ, мэдээллээр хэрхэн хангах асуудлыг харгалзан үзэх.

5. Энэ талаарх гадны орны туршлагыг харьцуулан судалж үзэх (тухайбал, Check My crime, Trick my crime³), байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын хувийн нууцтай холбоотой мэдээллийн нууцлалыг хангах асуудлыг харгалзан үзэх.

---0---

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

³ <https://www.police.wa.gov.au/Police-Direct/Check-my-crime>

ХАВСРАЛТ

Өмгөөлөгчдөөс хариулсан судалгааны дэлгэрэнгүй үр дүн

Асуулт-1. Таны өмгөөлөгчөөр ажилласан жил, Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагатай хир удаан холбогдон ажиллаж байна?

Судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 12 буюу 21.3% нь 1-3 жил, 11 буюу 19.6% нь 4-6 жил, 6 буюу 10.7% нь 7-10 жил, 27 буюу 48.2% нь 10-с дээш жил өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлсэн байна. Энэхүү ажилласан жилийн туршлага нь бидний судалгааны ажлын зорилтыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ гэж дүгнэж байна.

Асуулт-2. Өмгөөллийн үйл ажиллагаа явуулахад цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас ямар төрлийн мэдээллүүд танд илүү хэрэгтэй болдог вэ?

1. Хэргийн процесстой холбоотой мэдээ, мэдээлэл, сэжигтнээр татсан, хорьсон, баривчилсан үндэслэл, нотлох баримт;

2. Үйлчлүүлэгчийг ямар үндэслэлээр буруутган шалгаж байгаа, түүний гэм буруутайг нотлох баримтын талаарх мэдээлэл;

3. Хуулиар хориглосон, хувь хүний болон байгууллага, төрийн нууцад хамаархаас бусад мэдээлэл нээлттэй байх зайлшгүй шаардлагатай;

4. Хэрэг шалгалтын явцын талаарх мэдээлэл;

5. Гомдол хэрхэн шийдэгдэж байгаа, эрүүгийн хэрэг үүссэн эсэх тухай мэдээлэл;

6. Цагдаа: өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээлэл, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явц, хугацааны талаарх мэдээлэл (өмгөөлөгч биечлэн цагдаагийн байгууллагад очиж лавлахаас бусад тохиолдолд мэдээлэл авагддаггүй);

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага: Төлбөр төлөгчөөс төлбөр барагдуулах талаар удаашралтай хэргийн үндэслэл, шалтгаан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан ямар ажиллагаа гүйцэтгэсэн болох, төлбөр төлөгчийн эд хөрөнгийг эрэн сурвалжилсан эсэх талаарх мэдээллүүд. Эд хөрөнгө үнэлж буй шинжээчийг ямар журмын дагуу томилдог талаарх мэдээлэл;

8. Прокурор: Прокурорын даалгаварт ямар ажиллагаа гүйцэтгүүлэх талаар тусгагдсан мэдээллүүд, хэргийн материалд прокурорын даалгаврыг оруулдаг болох;

9. Шүүх: Тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлэх хугацааны талаарх мэдээллүүд, тухайн хэргийг шалгаж буй шүүгчийн хувийн байдлын талаарх мэдээллүүд. Жишээ нь хэргийн оролцогчтой төрөл садангийн холбоотой гэдгийг мэдэх ямар ч боломжгүй (Шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хүсэлт гаргахад ач холбогдолтой);

10. Үйлчлүүлэгчийн хэрэг дээр ажиллаж байгаа мөрдөн байцаагч, прокурор, шийдвэр гүйцэтгэлийн ажлтануудтай утсаар холбогдон бие биенийхээ ажилд хүндэтгэлтэй хандаж, уулзалтын цагийг товлох шаардлагатай байдаг. Гэтэл утасны дугаарыг өгөхгүй, туслахтай холбогдох талаар зөвлөдөг ч туслахууд нь шийдвэр гаргах эрхгүй тул холбогдох шаардлага төдийлөн байдаггүй;

11. Өргөдөл гомдолын дугаар болон хэргийн дугаар. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа болон тус ажиллагаанд хяналт тавьж байгаа албан тушаалтаны нэр, цол зэрэг

албаны мэдээлэл. Хэргийн ажиллагааны дүр зургийн талаарх холбогдох бусад мэдээллийг цаг алдахгүй авах (хэрэгт холбогдуулж гаргасан хүсэлт гомдлын шийдвэрлэлт гэх мэт);

12. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно гэсэн заалтын дагуу уг хэрэгт өөр өмгөөлөгч давхар ажиллаж байгааг цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар урьдчилан мэдээлдэггүй, ажиллагаа дуусах үед мэдэх жишээ байдаг;

13. Цагдаагийн байгууллага хэрэгт цугларсан нотлох баримт, мэдээ мэдээллийн эх сурвалжийг цаг тухайд нь мэдээллэх;

14. Шинээр илэрсэн нөхцөл байдлыг цаг алдалгүй мэдэгдэх шаардлагатай байна;

15. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эд хөрөнгө хураан авах, битүүмжлэх ажиллагааны товын талаар огт дурддаггүй;

16. Цагдан хорих ангид хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчийн эрүүл мэндийн байдал, санал хүсэлтийг цаг алдалгүй дамжуулдаг байх. Хэзээ хойно нь, 7-8 хоногийн дараа санал, хүсэлт нь ирдэг;

17. Тодорхой төрлийн хэрэг ямар үндэслэлээр шүүхийн шатнаас буцаж байгаа талаар шүүхээс хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт мэдээлэл өгдөг байх;

18. Хэргийн нотлох баримт, шинжилгээний хариу, гэрчийн мэдүүлэг, хэргийн газрын үзлэгээр хураан авсан эд мөрийн баримт зэргийг илт тодорхой болгомоор байна. Мөн шүүх хуралдааны үеэр гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээллээр гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогддог. Яг ямар мэдээ, мэдээлэл нотлох баримтаар цугларсаныг мэдээлдэггүй;

19. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулж байгаа, хэргийн шалгалтын явц байдал удааширч байгаа нөхцөл байдлыг танилцуулдаг байвал сайн байна. Мөрдөн байцаалтын 2 сарын хугацаа дуусахад л хавтаст хэрэгтэй танилцуулж тулгамдуулдаг;

20. Хүнийг санаатай алах хэрэгт өмгөөлөл явуулахад хэргийн нотлох баримт шинжилсэн баримт, гэрчийн мэдүүлэг, тодорхой ажиллагааны тэмдэглэл, үр дүн, шинжилгээний дүгнэлтийг цаг алдалгүй уншиж танилцах шаардлагатай болдог. Мөн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, прокурорын хяналт, шүүхийн шатанд шилжүүлсэн тухай мэдээлэл хэрэгтэй болдог;

21. Эрүүгийн хавтаст хэргийг өөр цагдаагийн газар, хэлтэст шилжүүлсэн тохиолдолд хэн гэдэг, ямар албан тушаалтанд шилжүүлсэн талаараа өмгөөлөгчид байх шаардлагатай. Учир нь хавтаст хэрэг өөр газар, хэлтэст шилжсэнтэй холбогдуулан ажиллагаа удаашрах асуудал үүсдэг;

22. Гэмт хэргийн нотлох баримт, түүнийг хэрхэн, ямар аргаар бэхжүүлж авсан, хэргийг нотлох тал дээр байцаалтаас өөр нотлох баримт хангалтгүй гэж боддог;

23. Хэрэгт хэдэн хүн холбогдсон, үйлчлүүлэгчийн оролцоо, мөрдөн байцаалтын ажиллагаа ямар шатанд байгааг мэдэх шаардлагатай байдаг ч мэдээлэл хаалттай байдаг. Эрүүгийн хэрэгт цугларсан мэдээ баримтын талаарх мэдээлэл хомс байдгаас болж өмгөөллийг хангалттай сайн хийж чаддаггүй. Энэ байдлаас болж яллагдагчид оногдуулах ялын хэмжээ нь их байдаг;

24. Шинээр батлагдаж байгаа хууль, дүрэм журамд заагдсан мэдээлэл хэрэг болдог. Тухайлбал, Улсын Ерөнхий прокуророос хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах аргачилсан заавар гаргадаг, энэ заавар сүүлд 2015 онд гарсан бөгөөд өмгөөлөгчид энэ талаар мэдээлэл огт өгөөгүйгээс болж хэргийн харъяаллыг мэдэлгүй цаг алдсан тохиолдол гарсан. Мөн тодорхой ажиллагаа явуулах газар, байршлын талаарх мэдээлэл, хэргийн хугацаа сунгасан, цагдан хорих

хугацаа сунгасан эсэх, гэмт хэргийн нийт үйлдэл, хохирол, хувийн байдал судалсан баримт зэрэг мэдээлэл хэрэгтэй байдаг;

25. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хэрхэн харьцах нь тодорхойгүй, уулзах боломжгүй байдаг, бусад хуулийн байгууллагатай хуульд заасны дагуу харьцдаг;

26. Бүх мэдээлэл хаалттай байдаг;

27. Бүх төрлийн мэдээлэл;

28. Дотоод журам, үйл ажиллагаа;

29. Цагдагийн байгууллага тодорхой төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл авдаг;

30. Гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шийдвэрлэх явц, ажиллагааны явц;

31. Хэрэг шалгаж байгаа мөрдөн байцаагчийн тухай, ямар шатанд байгаа, хохирол нөхөн төлөгдөх эсэх;

32. Өмгөөлөл явуулахад цагдаагийн байгууллагаас мөрдөн байцаагчийн шийдвэр. Жишээ нь: Цагдан хорих хугацаа сунгуулах санал прокурорт хүргүүлсэн эсэх, шинжээч томилох тогтоол, түүнд тавих асуултууд гэх мэт байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчийн шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

33. Хэдийгээр тухайн байгууллагын дотоодод мөрддөг дүрэм журам боловч үйл ажиллагаанд баримтлах заавар, журам (Прокурорын байгууллагад хэрэглэгддэг Хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих аргачилсан заавар), мөн тухайн байгууллага тус бүрийн ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм, үйл ажиллагааны стандарт (Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагааны стандарт) зэрэг баримт бичгүүд нь нууцлаад байх шаардлагагүй, харин ч нийтэд ил тодорхой байх нь зүйтэй санагддаг;

34. Шүүхийн тухайд: шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээллүүд, статистик, шийдвэрлэсэн болон хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо, хэрэгсэхгүй болгосон болон нэмэлт мөрдөн байцаалтад буцааж буй шалтгаан зэргийг тоймлон мэдээлж байвал тухайн байгууллагын албан хаагчдад ч ач холбогдолтой байх болов уу. Байгууллагын бүтэц, хэлтэс тасгуудын чиг үүрэг, гомдол, хүсэлт хүлээж авч шийдвэрлэх ахлах, удирдах албан тушаалтанууд нь ямар цол, эрэмбэтэй, хэн болох талаарх мэдээлэл дутмаг байдаг. Шинэ томилгоо, халаа сэлгээтэй холбоотойгоор орсон өөрчлөлтүүдийг цаг тухайд нь ядаж өөрсдийн веб сайтад оруулж байх нь зүйтэй болов уу?;

35. Албан хаагчдын нэрс, утасны жагсаалтын талаарх мэдээлэл. Зарим тохиолдолд шинээр томилогдсон шүүгч, прокурор нарын албан тушаал, зэрэг цолны талаарх мэдээлэл;

36. Үйл ажиллагааны чиг үүргээс шалтгаалж авах мэдээллүүд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, прокурорын үйл ажиллагаа хэт нэг талыг барьсан яллах чиг үүргээ давамгайл хэрэгжүүлж байгаагаас таслан сэргийлэх арга хэмжээг (цагдан хорих) өөрчлөх, хугацаа сунгах зэрэг асуудлыг дангаараа шүүхэд хандан шийдвэрлүүлэх нь байсаар байгаа. Хэдийгээр өмгөөлөгчийн зүгээс хүсэлт гаргадаг ч тухайн асуудлыг шийдвэрлэх хуралд оролцуулдаггүй, шүүхээс хурлын тов зэрэг мэдээлэл өгдөггүй хаалттай байдлыг зогсоох хэрэгтэй. Болвол шүүхээс цаг тухайд нь таслан сэргийлэх арга хэмжээний хурлын товыг хүсэлт гаргасан өмгөөлөгчид нэн даруй, нээлттэй мэдээлэх шаардлагатай;

37. Мөрдөн байцаагч, прокурорын ажлын цагийн хуваарь, тухайн хэрэгт ажиллагаа хийхээр гаргасан төлөвлөгөө, хүсэлт, гомдлыг хянан шийдвэрлэсэн тогтоол, шийдвэрийн үндэслэл дэлгэрэнгүй байх;

38. Гэмт хэрэг гарсан нөхцөл байдал, холбогдох нотолгоо, хохирогчийн хувийн байдлын талаар;

39. Тухайн хэргээс хамааран харилцан адилгүй байдаг. Хэргийн талаар ямар нотлох баримт цугларч байгаа талаар мэдээлэл;

40. Хүсэлт, гомдол гаргах гаргах журмын талаарх мэдээлэл;

41. Хуваарилагдсан албан тушаалтан, хугацааны талаарх мэдээлэл;

42. Хууль зүйн баримт бичгийг үндэслэлтэй, бодитой боловсруулж асуудлыг нэг мөр шийдвэрлэж чаддаггүй. Тэр чиглэлийн мэдээллүүд илүүтэй дутагддаг;

43. Хэргийн шийдвэрлэлтийн талаар нээлттэй санал, хүсэлтийн хариуг цаг хугацаанд авах;

44. Хэргийг шалгаж байгаа ажиллагааны талаар тухай бүр мэдээлэл шаардлагатай байдаг;

45. Холбогдох хэргийн материалыг цаг тухайд нь танилцуулах;

46. Шүүхийн эцсийн шатанд биш өмгөөлүүлж байгаа үйлчлүүлэгчийн үйлдэл холбогдлыг тухай бүр нь мэдэж өмгөөллийн үйл ажиллагаанд ач холбогдолтой мэдээлэл авах шаардлагатай байдаг;

47. Нууцын тухай хуульд тогтоосноос бусад мэдээллийг өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, мэтгэлцээнийг бүх шатанд бий болгох хэрэгтэй, ийм нөхцөл бүрдээгүй, сэтгэлгээг өөрчлөөгүй тохиолдолд шийдвэрүүд нууцаар гарч, хүний эрхийг зөрчсөөр байх болно;

48. Хэнийг хаана хорих асуудал.

49. Цагдан хорих хугацааг үргэлжлүүлэн сунгах саналаа шүүхэд явуулахдаа өмгөөлөгчид нь давхар мэдэгддэг байвал бидний ажилд их хэрэгтэй байдаг. Хугацаа сунгах саналаа 7 хоногийн дотор явуулдаг тул яг хэзээ тухайн санал шүүхэд очих гэж байгаа нь мэдэгдэхгүй өнгөрөх тохиолдол гардаг;

50. Гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах талаарх мэдээлэл муу байдаг;

51. Гэмт хэрэгт холбогдсон болон хохирсон иргэний эрх ашгийг хамгаалахаар мэдээ мэдээллийг нээлттэй байдлаар хүргэдэггүй;

52. Мэдээлэл төдийлөн тодорхой бус байдаг. Ялангуяа цагдаагийн байгууллага мөрдөн байцаалтын ажиллагааны 60-70 хувийг хийж гүйцэтгэдэг атлаа мэдээлэл хангалтгүй өгдөг;

53. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хорих ангийн ажиллах журам, уулзалтын журам, байршил, албадан ажил хийлгэх бол хэдэн цагийн, ямар үнэлгээтэй ажил хийх талаар мэдээлэл хүсдэг;

Асуулт-3. Гэмт хэрэгт холбогдсон, хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас ямар мэдээ, мэдээллийг нээлттэй байдлаар хүргэдэг вэ?

1. Тийм мэдээлэл одоогоор аваагүй байна;
2. Дээрх байгууллага нь хүнд сурталтай бөгөөд мэдээ мэдээллийг хуулиар олгосон хүрээнд олгодог.
3. Урьдчилан сэргийлэх мэдээлэл л харж байсан;
4. Өнөөдрийг хүртэл нээлттэй байдлаар мэдээлэл авч байгаагүй;

5. Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Дээд шүүх, Цагдаагийн ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын газраас мэдээлэл хүргүүлдэг. Энэхүү мэдээлэл нь зөвхөн гэмт хэрэгт холбогдсон иргэдийн статистик мэдээлэл гардаг бөгөөд гэмт хэгийн улмаас хохирсон иргэдийн эрх ашгийг хэрхэн хамгаалсан талаарх мэдээлэл гардаггүй;

6. Хэргийн холбогдогч нар нь цагдан хоригдож байх үедээ хүндээр өвчилсөн бол таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилсөн талаар мэдэгддэг. Түүнээс өмнө нь эрүүл мэндийн байдал тодорхойгүй байдаг;

7. Хавтаст хэрэгтэй танилцах, таслан сэргийлэх арга хэмжээний талаар, хяналтын прокурорын талаар, гэмт хэрэг хамтран үйлдсэн этгээдүүдийн талаар мэдээлдэг. Шүүхээс шүүх бүрэлдэхүүний талаар болон шүүгчийн захирамжийн талаар мэдээлдэг;

8. Хэргийн хугацаа, хохирогчийн хувийн мэдээлэл, таслан сэргийлэх арга хэмжээний үр дүн, явц байдлыг танилцуулдаг. Эрүүгийн хэрэг шүүхийн шатанд байх үед сэжигтэн, яллагдагч нартай уулзах цаг хугацаа болон шүүх хурлын товыг мэдээлдэг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар цугларсан нотлох баримтыг прокурорын шатанд мэдэгдэх бөгөөд эд мөрийн баримт, хохирол нөхөн төлүүлэлтийг нээлттэй байдлаар хүргэдэг. Мөн гэмт хэргийн сэжигтэн яллагдагч нарын үйлдсэн өөр төрлийн хэргүүдийн талаар мэдээлдэг;

9. Сэжигтэн, яллагдагчийн хувийн байдал, зан байдлын тодорхойлолт, шүүхийн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолын хуулбар, тодорхой ажиллагааны тэмдэглэл зэргийг цаг алдан байж мэдээлдэг.

10. Цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчийг аль камерт хоригдож байгаа болон хэзээ цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дуусч байгааг мэдээлдэг;

11. Хохирсон иргэд, аж ахуй нэгж байгууллагын эрх ашгийг хамгаалах тал дээр нэг хэсэг Тахарын ерөнхий газар байгууллагдаж нэлээн анхаарч ажилсан боловч татан буугдаад буцаад цагдаагийн байгууллагад хамаарах болсон нь ухралт болсон.

12. Сэжигтэн, яллагдагч болон хохирогч нарын талаарх мэдээлэл цагдаагийн байгууллагаас харьцангуй бага өгдөг хэргийн материалтай танилцах хугацаа бага байдаг харин прокурор, шүүхээс илүү олж мэддэг;

13. Хавтаст хэрэгтэй танилцаж тал бүрээс нь судалдаг;

14. Хэвлэл мэдээллийн хэргслээр хүргэдэг;

15. Тухайн албан тушаалтны ажлын цагийн хуваарийг баримжаалхад төвөгтэй, тодорхой алба тушаалтны баталсан дүрэм журам;

16. Бүх мэдээллийг өөрөө гуйж байж авдаг;

17. Огт хүргэдэггүй;

18. Хэрэг хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх мэдээлэл;

19. Сайн хүргэдэггүй, хохирол сайн төлүүлдэггүй;

20. “Shuukh.mn” цахим хуудсанд шүүхийн шийдвэрийг байршуулдаг. Эрх ашгаа хамгаалах, хууль тогтоомжид заасан эрх, үүргийг маш сайн тайлбарлах шаардлагатай байна;

21. Иргэдэд нээлттэй хүргэдэг мэдээллүүд хангалтгүй. Харин цагдаагийн байгууллагаас хааяа гэмт хэргээс урдчилан сэргийлэх талаарх мэдээллийг телевиз болон бусад мэдээллийн хэрэгслээр явуулдаг ч энэ нь зорилгодоо төдийлөн хүрдэггүй. Тухайлбал, “G time” зэрэг луйврын сүлжээтэй холбоотой асуудлыг иргэдэд сэрэмжлүүлэх оролдлогууд хийгдсэн боловч тухайн хууль бус үйл ажиллагаа эхлэх үед нь бус тухайн луйврын үйл ажиллагаа үндсэндээ дуусахад, олон мянган иргэд хохирсны дараа л урдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой мэдээллүүд цацагдаж эхэлсэн. Ингэхээр мэдээлэл нь цаг үеэ олох, мөн зорилтот хэсэгтээ хүрэх асуудал чухал. Хэрэгт холбогдсон иргэдийн эрх ашигтай холбоотой мэдээлэл үндсэндээ маш хангалтгүй;

22. Шүүхээс иргэдэд нээлттэй мэдээлэл хүргэх нь бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй дэвшилттэй, шуурхай байгаа ч ихэнхдээ шийдвэрлэгдсэн хэргийн талаар мэдээлэл өгөхөөс хэтэрдэггүй. Иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг

зөрчлөөс урдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээллүүд төдийлөн хангалтгүй. Прокурорын байгууллагаас иргэдэд чиглэсэн мэдээлэл хангалттай биш;

23. Хэрэг хуваарилагдсан мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн талаарх мэдээллийг нээлттэй байдлаар авдаг;

24. Энэ талаарх мэдээ, мэдээллийг дээрх байгууллагууд нээлттэй байдлаар хүргэж үйлчлэх нь хангалтгүй. Тухайн байгууллагын мэдээллийн самбар дээр “таны төлөө ” гэсэн лоозон маягийн мэдээлэл л байдаг;

25. Хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээ, бас гэмт хэргийг илт сурталчлахгүй байх;

26. Эрх, ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах;

27. Өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

28. Мэдээлэл хүрдэггүй;

29. Өмгөөлөгч авах, өөрийн эрх ашгийг хамгаалах талын мэдээлэл хэрэгтэй;

30. Мэдээ, мэдээллүүд нь тэр бүр нээлттэй ил тод байж чаддаггүй. Хэргийг нууц хэмээн хуульд заагаагүй үндэслэлээр нууцалдаг;

31. Мөрдөн байцаагчийн зөвшөөрсөн хэмжээнд мэдээ, мэдээллийг авдаг;

32. Мэдээллүүд нээлттэй биш байдаг;

33. Ихэвчлэн мэдээлэл өгөхөөс зайлсхийдэг;

34. Зохих албан тушаалтантай уулзаж амаар хүсэлт гаргадаг. Мөн хуульд заасан үндэслэлээр бичгээр санал, хүсэлт гомдол гаргадаг;

35. Хэргийн оролцогчдын эрх, үүрэг;

36. Шүүхийн мэдээлэл нээлттэй байдаг. Цагдаа, прокурорын байгууллагын мэдээлэл хаалттай байдаг;

37. Хаалттай байдаг;

38. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд бүхий л мэдээлэл хаалттай байдаг;

39. Гэмт хэрэгт холбогдсон хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор тэдний ар гэр найз нөхдийн мэдээллийг нээлттэйгээр хүргэдэг;

40. Гэмт хэрэгт холбогдсон иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар хуулийн байгууллагаас мэдээ мэдээллийг нээлттэй хүргээд байдаггүй;

41. Эрх, эрх чөлөөг баталгаажуулсан, үүрэг хүлээлгэсэн хуулийн талаарх мэдээлэл, гаргасан саналд хугацаанд нь хариу өгч байх шаардлагатай. Эсвэл хүсэлтэй холбоотой асуудал хариуцсан ажилтантай болох шаардлагатай;

42. Тухайн хэргийн өмгөөлөгч биш тохиолдолд мэдээлэл хаалттай байдаг.

Асуулт-4. Эрүүгийн байцаан шийтгэх болон шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэх ажиллагааны явцад оролцогчид болон түүний гэр бүлийн гишүүдээс ямар мэдээ, мэдээллийн талаар илүү их хүсдэг вэ?

4. Хуулийн зөвлөгөө, дүгнэлт, гаргалгаа, цаашид хэрхэх, сэжиглэгдсэнээс эхлээд хоригдох, суллагдах хүртэлх бүхий л процесс, хуулийн байгууллагын мэдээ, мэдээлэл, дүрэм журам гэх мэт;

5. Хуулиар хориглоогүйгээс бусад төрлийн мэдээ мэдээллийг ил болгож хүсэлт гарган авах хүсэлтэй иргэдэд түргэн шуурхай гарган өгч байх шаардлагатай;

6. Гэм буруутайг нотолсон нотлох баримт;

7. Цаашид гарах үр дагавар, цагаатгагдах боломж, ял хөнгөрүүлэх боломж, иргэний нэхэмжлэл хангагдах зэрэг мэдээллийг илүү их авахыг хүсдэг;

8. Ялтан хаана ямар ял эдэлж байгаа, тэдний ажил хөдөлмөр эрхлэлт, цалин хөлстэй холбоотой мэдээлэл, өмч хөрөнгийн талаарх мэдээллийг гаргуулах хүсэлтэй байдаг;

9. Байцаан шийтгэх ажиллагаа хэрхэн явагдаж байгаа талаар байнга асуудаг. Мөрдөн байцаалтын ажиллагаа дуусаагүй тохиолдолд ар гэрт нь ямар нэг зүйл хэлэх боломжгүй байдгийг зарим иргэд ойлгоно. Зарим иргэдийн ойлгохгүй байдал, ойлгохыг хүсэхгүй байдал нь бидний ажилд төвөгтэй байдал үүсгэдэг. Мөн зарим гэр бүлийн гишүүнээс шүүхээс оногдуулах ял шийтгэлийн асуудлаар өмгөөлөгч нараар амлалт авахуулах байдлаар харилцах тохиолдол байдаг. Мөн хуулийн байгууллагад ямар танил талтай вэ? гэсэн асуудлт асуудаг;

10. Өмгөөллийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдана гэдгийг эхнээс нь ойлгуулсан тохиолдолд дээрх байдал үүсэх нь бага байдаг;

11. Хэргийн нөхцөл байдлын талаар бодит мэдээлэл авах;

12. Хэргийн хөдөлгөөний талаарх мэдээлэл;

13. Ихэвчлэн хэрэг хэзээ шийдвэрлэгдэх талаар;

14. Надад өөр үйлдсэн хэрэг байгаа үүнийгээ цагдаад ярих уу;

15. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэх;

16. Гэмт хэрэг хамтран үйлдсэн этгээдүүд баригдсан эсэх;

17. Эхнэр хүүхэд ямархуу байгаа бол гэж асуудаг;

18. Харин ар гэрийн хүмүүс нь мөрдөн байцаагч хэрэг удаан шалгаад байна, нэг талыг барьж ажиллаад байна, тэр ч байтугай мөрдөн байцаагч хээл хахууль авсан юм биш байгаа гэж хүртэл асуудаг. Сэжигтэн, яллагдагч нарын ар гэрээс хэдэн жилийн ял шийтгэгдэх бол, тэнсэн харгалзах болов уу гэж асуудаг. Хохирогчийн талаас одоо дахиж хэзээ байцаалт өгөх бол гэж асуудаг;

19. Хэргийг шийдвэрлэх хугацаа болон гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон эсэх зэргийг ихэвчлэн асуудаг. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдийн ар гэрийн хүмүүсээс цагдан хорих болов уу, байцаагч нь ямар хүн байна, хэргийг хэдэн сар шалгах вэ? гэх мэтийн асуулт асуудаг;

20. Хохирогчийн ар гэрээс хэзээ хэрэг шийдэгдэх бол, гэмт хэрэг үйлдсэн хүн нь одоо хаана байгаа вэ, бидний хохирлыг хэзээ барагдуулах бол, төлбөрийн чадамжтай хүн юм уу гэх мэт зүйл асуудаг. Гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч нар манай байцаагч хэргээ удаан шалгаад байна, солиулмаар байна, яав вэ гэж асуудаг. Мөн зарим төрлийн гэмт хэрэгтэн цагдан хоригдож байх хугацаандаа ял шийтгэгдэхээ мэдсэн байдөг бөгөөд хуурамч гэмт хэргийн талаар цагдаад мэдээлэл өгч хуулийн байгууллагыг төөрөгдөлд оруулж хугацаа хождог. Сэжигтэн, яллагдагч нарын ар гэрээс хоригдож байгаа хүнтэй хэзээ уулзаж болох талаар асуудаг;

21. Шүүхийн таван шийдвэрлэх шийтгэх тогтоол гүйцэтгэх ажиллагааны хүрээнд ар гэрийн хүмүүс нь хэзээ хэрэг шийдвэрлэгдэх бол, бидний эд зүйлсийг буцаан хүлээлгэн өгөх үү, хохирогч нь ямар хүн байдаг юм бол, уулзаж болох уу? гэж ихэвчлэн асуудаг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд сэжигтэн, яллагдагч нарын ар гэрээс хохирлыг нь барагдуулвал хэрэг яаж шийдвэрлэгдэх бол, заавал барагдуулах хэрэг байна уу, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлж болох уу? гэх мэт зүйлийг асуудаг;

22. Сэжигтэн, яллагдагч нарын ар гэрээс ихэвчлэн шалгаж байгаа мөрдөн байцаагчийн талаар болон ийм төрлийн гэмт хэрэг холбогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар асуудаг. Эрүүгийн хэрэг, гомдол мэдээллийн шатанд таслан сэргийлэх арга хэмжээ хэрхэн яаж авах талаар асуудаг. Ар гэрт нь цагдан хоригдож эхэлсэн цаг хугацаа, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэзээ өөрчлөх зэргийг хэлдэггүй учир мэдээлэл хомс байдаг.

23. Хохирсон иргэдийн тухайд хэргийг үнэн бодитой шалгаж шийдвэрлэсэн эсэхэд эргэлзээ төрдөг учраас энэ төрлийн мэдээлэл авахыг илүү хүсдэг. Харин гэмт хэрэгт холбогдсон иргэний тухайд ямар арга замаар ялаас чөлөөлөгдөх, хөнгөн ял шийтгэгдэх талаар мэдээлэл авахыг хүсдэг;

24. Гэмт хэрэгт холбогдсон этгээдүүд өөрийн үйлдлийг зүйлчилж байгаа зүйл, хэсэг нь зөв эсэх талаар болон хохирлын дүнгийн талаар их асуудаг;

25. Хувийн байдлын мэдээлэл болон хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт, эх сурвалж тодорхойгүй байдаг. Оролцогч нарын ар гэрээс хэргийн шийдвэрлэлт, хэрэгт гаргаж өгөх баримт сэлтийн талаар ихэвчлэн асуудаг. Мөн батлан даалтанд шалгагдаж байгаа этгээдийг хэрхэн хараа хяналтандаа авах талаар асуудаг нь батлан даалтанд авч байгаа хүмүүсийн хувийн байдлыг судлаагүйг харуулж байна;

26. Хэргийн бодит байдлыг тогтоосон мэдээллийг илүү олж авахыг хүсдэг. Эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн хохирогчийн ар гэрийнхэн нь хэргийг хурдан шийдвэрлэх болов уу? гэж ихэвчлэн асуудаг. Ихэнхдээ хэрэг шалгах ажиллагаа удааширч байгаа шалтгаан бол гэмт хэрэг хамтран үйлдсэн этгээд тогтоогдохгүй, түүх соёлын хосгүй үнэт зүйлийн үнэлгээг зөв гаргаж чаддаггүй, таслан сэргийлэх арга хэмжээг оновчтой хэрэглээгүй, байцаан шийтгэх процессийн ажиллагааг зөрчиж гүйцэтгэсэн зэрэг үндэслэлээр удааширч байна;

27. Сэжигтэн, яллагдагч нарын ар гэрээс цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг хэзээ өөрчлөх бол, шүүх хурлыг хэзээ товлосон бэ? Гэх зэрэг асуултыг асуудаг;

28. Юунаас болж хүн хохирсон талаар эсвэл яагаад ял шүүтгүүлж байгаа талаар тодордуулдаг;

29. Байцаан шийтгэх ажиллагааны явцад гарсан шийдвэрийг бичгээр танилцуулахдаа хойрго ханддаг, амаар хэлэх төдийд өнгөрөөх гэдэг, хэргийн хөдөлгөөний талаарх мэдээлэл;

30. Гэм буруугийн байдлын талаар болон учирсан хохирол;

31. Хэргийг хэрхэн яаж нотолсон талаар;

32. Хэрэг хурдан шийдвэрлэгддэг, хохирол барагдах;

33. Уулзалт, эргэлтийн хувиар, уулзалт, эргэлтийг зохион байгуулах журам, цагдан хоригдсон хүний хувийн данс, эрүүл мэндийн байдал зэрэг;

34. Байцаан шийтгэх ажиллагааны оролцогчийн тухайд байцаан шийтгэх ажиллагаанд хэр удах вэ?, Прокурор ямар хугацаанд хянадаг юм бэ?, Шүүхийн шатанд шилжинэ гэсэн нь юу гэсэн үг вэ?, Ер нь одоо шалгаж эхэлж байгаа хэрэг хэдий хугацаанд шалгагдаж дуусах вэ?, Гомдол гаргавал хэнд гаргах вэ?, Гомдлыг хүлээж авсан албан тушаалтан хэдий хугацаанд хянаж шийдвэрлэдэг юм бэ?, Гомдлын хариугаа яаж авдаг вэ?, Шийдвэр гарсан талаар бидэнд мэдэгдэх ёстой юу?, Прокурор яг ямар үүрэгтэй хүн бэ? гэх зэрэг ерөнхий ойлголтыг авахыг хүсч байна;

35. Шалгаж байгаа хэрэг дээд шатандаа хаана хүрч дуусах зэрэг цаг хугацааны үргэлжлэлтэй холбоотой асуудал хэргийн оролцогчид болон тэдгээрийн ар гэрийнхний сонирхлыг илүүтэй татдаг болох нь харагддаг. Гарч болзошгүй ямар ямар шийдвэрүүд байдаг талаарх мэдээлэлийг сонирхох нь олон бий;

36. Хэргийн оролцогч болон гэр бүлийнхний зүгээс хэрэг хувиарлагдсан мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн талаарх мэдээллийг хүсдэг;

37. Тухайн шийдвэр, тогтоолын хууль зүйн үндэслэл болон тийнхүү шийдвэрлэх болсон шалтгаан;

38. Хэргийн холбогдогчид ногдох эд хөрөнгийн талаар;

39. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа;

40. Илүү дэлгэрэнгүй байдлаар хэргийн талаарх баримт сэлт, мэдээ, мэдээллийг олж авахыг хүсдэг;

41. Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд эцсийн шийдвэр хэрхэн гарсаныг зайлшгүй мэдэх хэрэгтэй байдаг;

42. Ямар үндэслэлээр цагдан хорих болсон, цаашид ямар үндэслэлээр хугацаа сунгаж байгаа талаарх мэдээлэл;

43. Хавтаст хэрэгтэй танилцахыг хүсдэг;

44. Байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид хэрэг, маргааныг хэзээ, хэрхэн, хэн шийдвэрлэсэн талаар шуурхай хариу өгч байвал зүгээр;

45. Гэрч, хохирогч тэдний мэдээлэл хувийн анкет, нууцлалгүй ил задгай байдаг нь сөргөөр нөлөөлөх магадлалтай гэж байнга хүсэлт гаргадаг;
46. Хохирогч сэжигтэн, яллагдагчийн хувийн байдлын талаар мэдээлэл авахыг хүсдэг;
47. Холбогдогчийн хувьд: хэргийг шалгаад холбогдуулах болсон үндэслэл, шийдвэрлэлт;
48. Хохирогчийн хувьд: эрх, ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах буюу нөхөн сэргээх, хохирол барагдуулах үндэслэл, боломж;
49. Гэрч болон бусад оролцогчийн хувьд: гомдол, мэдээлэл, хэргийг шалгаж буй алба хаагч, хугацаа, гаргасан саналд хангалттай хариу өгөхгүй байгаа үндэслэл, шийдвэрлэлт;
50. Хоригдож буй этгээдийн эрүүл мэндийн байдал, гомдол, түүний шийдвэрлэлт.

Асуулт-5. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас гомдол, мэдээлэл, хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийн талаарх ямар мэдээллийг иргэдэд ил тод болгох боломжтой гэж Та үздэг бэ?

4. Мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч хавтаст хэрэгтэй танилцах боломжтой байх;
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад барагдуулсан хохирлын хэмжээ;
6. Хуулиар хориглосноос бусад төрлийн мэдээ, мэдээлэл;
7. Явцын талаарх мэдээлэл;
8. дээрх байгууллагаас иргэдэд гэмт хэргийг шалган шийдвэрлэж байгаа үйл явцын тухай дэлгэрэнгүй мэдээллийг өгч байх хэрэгтэй. Хэргийн оролцогч нь хэргийг шийдвэрлэж буй үйл явцын тухай тодруулахад ихэнх тохиолдолд Танд тайлбарлах нь бидний ажил биш, Та эрх зүйн туслалцаагаа өмгөөлөгчөөсөө ав гэж хариулдаг. Энэ тухай мэдээллийг цаг тухайд нь авч байх нь хууль зүйн туслалцаа аваагүй хэргийн оролцогчид нэн чухал шаардлагатай байдаг ба мэдээлэл аваагүйгээс эрх нь зөрчигддөг;
9. Төр байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад бүх мэдээллийг ил тод болох боломжтой;
10. Иргэдэд гэмт хэрэг, зөрчил багасч, иргэдийн ухамсар дээшилж байгаа гэсэн эерэг мэдээлэл чухал гэж боддог. Нийгмийн сэтгэл зүйг эерэг байдлаар чиглүүлэхгүй бол муу талын мэдээлэл нь бүгд л ийм байхад би тэднээс ялгараад байх шаардлага байхгүй гэсэн бодолд хүргэдэг тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил хийгдээсэй гэж боддог;
11. Гэмт хэргийн үзүүлэлт, тоо баримт, дүн шинжилгээтэй холбоотой мэдээ, мэдээллүүд л нээлттэй байж болно;
12. Цагдаагийн байгууллага гүйцэтгэх ажлын мэдээллээс бусад мэдээллийг ялангуяа бүртгэгдсэн өргөдөл, гомдлын шинж чанараас хамаарч энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ёстой;
13. Хэргийн цаашдын явц байдал, хэргийг прокурорт шилжүүлсэн цаг хугацаа, эд хөрөнгө битүүжлэх, хураан авах ажиллагааг хэзээ хаана явуулахаа мэдэгддэг байх;
14. Хэрэг шалгаж байгаа мөрдөн байцаагч, хяналтын прокурор, шүүгчийн нэр хаягийг хэргийн холбогдогчийн ар гэрийн хүмүүст сайтар мэдэгддэг байх ёстой. Мөн цагдан хорих талсан сэргийлэх арга хэмжээ авсан бол эргэлт хэзээ хийх зэргийг нь мэдээлдэг болмоор байна. Юу ч болоогүй байхад сэжигтэн, яллагдагчийн ар гэрээс уулзалт яаж хийх үү гэж асуудаг;
15. Гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ, мэдээллийг шүүх хуралдааны дараа мэдэгддэг байвал сайн байна. Мөн сэжигтэн, яллагдагч нарын ар гэрээс гаргасан санал, хүсэлтийг мэдээлдэг болмоор байна. Мөрдөн байцаагч нар цаг хугацаа алдаж хэрэгт холбогдолтой мэдээ, мэдээллийг дамжуулж байна. Тухайлбал, таслан сэргийлэх арга хэмжээ өөрчилсөн тухайгаа дэр даруйд нь мэдэгддэггүй. Нэгжлэг, эд зүйл хураан авах, мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулдаггүй, харин уг ажиллагааныхаа

тэмдэглэлд оруулсан байх жишээ байдаг. Дээрх мэдээ мэдээллийг өмгөөлөгчдөд мэдэгдэх боломжтой байна;

16. Хэргийг шалгах явцад тулгамдсан асуудал болон хохирлын хэмжээ мөрдөн байцаалтын ажиллагааны явцад яаралтай төлөх талаар мэдээлэл өгөх ёстой. Мөн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу гэмт хэрэг илрүүлэх, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн ар гэртэй уулзалт зохион байгуулж тодорхой мэдээлэл өгч баймаар байна. Хүн бүртэй ойрхон уулзаж ярилцаж үйл ажиллагаагаа явуулдаггүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цагдан хоригдож байгаа сэжигтэн яллагдагчийн санал, хүсэлт, эрүүл мэндийн байдлыг нь танилцуулж хэвших;

17. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл болон эрүүгийн хэргийн баримт нь хувь хүний нууцтай холбоотой асуудал байдаг учраас иргэдэд ил тод болгох шаардлагагүй гэж үзэж байна;

18. Хуулийн сурталчилгаа сайн хийгдэх хэрэгтэй. Учир нь гэмт хэрэгт холбогдсон хүмүүс хуулийн мэдлэг тун дутмаг байгаа нь илт харагддаг;

19. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг зөвлөмж хүргүүлэх. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхээс иргэдэд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэдэн жилийн ял шийтгэгдэж байгаа гэдгийг таньж мэдүүлэх шаардлагатай байна;

20. Гомдол, мэдээлэл хэрэг, зөрчлийн талаар хуулийн хугацаанд шалгаж дуусаад хариу мэдэгдэх хуудсыг дэлгэрэнгүй хүргэж байх, цаашид хийгдэх ажиллагааг товчхон мэдээлдэг болох. Ер нь цагдаагийн байгууллага аливаа нэг мэдээллийг хэргийн ангиллаас нь шалтгаалж удаан гаргадаг. Харин шүүх, прокурорын байгууллага цаг алдалгүй хүргэдэг гэж би дүгнэдэг;

21. Нийгэмд сөрөг нөлөө бүхий гэмт хэргийн талаарх мэдээллийг ил болгох, жишээ нь дээрмийн гэмт хэргийн талаар мэдээлэл, хор холбогдлын талаар ил болговол хүүхдүүд сэрэмжилнэ гэж бодож байна;

22. Өсөх хандлагатай байгаа хэрэг зөрчлийн талаарх мэдээлэл болон түүний шалтгаан, нөхцлийг тодорхойлох, энэ талаар урдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллийг цагдаа, шүүх, прокурорын байгууллагууд аль аль нь өгч байх нь зүйтэй.

23. Хэргийн оролцогчийн талаарх мэдээлэл, мөн шалгаж байгаа мөрдөн байцаагч, хянаж байгаа прокурор, шүүгчийн мэдээллийг ил тод болгох боломжтой;

24. Тухайн хэргийг шалгах хугацаа болон ямар шатанд байгаа, тухайн шатанд хэд хонож байгаа, хугацаа сунгагдсан зэрэг мэдээллийг нээлттэй цахим болгох хэрэгтэй;

25. Дээрх мэдээлэл нь хувь хүний нууц болон хүний эрхтэй холбоотой учир нээлттэй болгоход онцгойлон анхаарах хэрэгтэй;

26. Хэргийг шийдвэрлэх хугацаа, явц, хэн шийдвэрлэж байгаа, хэрхэн шийдвэрлэснийг оруулж байх;

27. Хэргийн бодит үнэнг тусгасан тайлбар, түүвэр, мэдээлэл, холбогдох тогтоол, шийдвэр, захирамж гэх мэт;

28. Хангалттай хүргэдэг гэж бодож байна;

29. Хэргийг шүүхээр шийдвэрлэсэн талаарх албан ёсны мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонингоор нийтэлдэг байх;

30. Шүүхээс хэргийг хянаж эцэслэн шийдвэрлэсний дараа мэдээллийг ил тод, нээлттэй болгох хэрэгтэй;

31. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэхгүй байх, удаашрах, дуудлага худалдаанд оруулах талаар гомдол гаргаж хугацаа хаах ажиллагааны төлбөр авч байгаа нь хохирч байна;

32. Гэмт хэргийн хор уршгийг иргэдэд байнга нээлттэй мэдээлэх нь ач холбогдолтой;

33. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, прокурор, шүүхэд ирж байгаа гомдол, мэдээллийг шаардлагатай хуулийн ажилтан танилцаж байх нь зохимжтой болов уу;

34. Хэрэг шийдвэрлэлтийн явц, хэргийн зүйлчлэл, хийсэн ажиллагааны талаарх мэдээлэл.

Асуулт-6. Нэмэлт санал:

17. Шүүхийн шийтгэх тогтоолууд хууль зүйн хангалттай үндэслэл бүхий, эргэлзээгүй, нэг мөр ойлгомжтой гарч чаддаггүй. Энэ нь шүүгчдийн мэргэжлийн чадвартай холбоотой байх, яагаад гэмт хэрэг гэж үзэж ял шийтгэж байгаа нь гаргалгаа муутай хэт ерөнхий байдаг. Бас шүүгчид шийдвэрлэх гэж байгаа хэргээ сайн уншиж, судалдаггүй, гол гол баримтыг нь олоод уншдаг байж болох ч энэ нь хангалтгүй, зарим тохиолдолд харалган шийддэг;

18. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүх хуралдаанд сэжигтэн, яллагдагч, тэдний өмгөөлөгчийг байлцуулан, хорьж байгаа үндэслэл дээр хариу тайлбар өгөх боломжийг олгох;

19. Өмгөөлөгч үйлчлүүлэгчээрээ дамжуулан шинжээч томилсон тогтоолтой танилцдаг биш өөрөө шууд танилцах эрхийг хуулиар олгож өгөх нь зүйтэй;

20. Эрүүгийн хэрэг үүсгэсэн үеэс эхлэн өмгөөлөгч хавтаст хэрэгт цугларсан нотлох баримттай танилцах эрхээр хангах;

21. Иргэдтэй харилцах харьцаанд анхаарах, соёлтой байх, албан хаагчдын тоог нэмэх, ачааллыг багасгах, түргэн шуурхай байх, орчин үеийн техник тоног төхөөрөмжийг ашиглаж сурах, цахим хаягаар харилцах;

22. Гомдол, эрүүгийн хэргийг хэрхэн шалгаж шийдвэрлэж байгаа, хуулийн хугацаанд шийдвэрлэж байгаа эсэх, ямар шатанд, ямар байгууллагын хяналтанд байгаа талаарх мэдээллийг цахим орчноос харах боломжоор хангавал өмгөөлөгчийн оролцоо илүү үр дүнтэй байх болно;

23. Сэжигтэн, яллагдагч нарыг үйлдсэн хэргийн өнгөөс нь хамаарч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг аль болох багасгамаар байна;

24. Өмгөөлөгчийг татгалзах санал хүсэлт гаргасан даруйд нь бидэнд мэдээлдэг байх. Хэрэг шийдвэрлэх явцад өөр өмгөөлөгч авсан талаар нь хэлдэг;

25. Цагдаагийн байгууллага хавтаст хэрэгтэй танилцахад цаг хугацаа гаргаж өгмөөр байна. бүрэн танилцаагүй байхад прокурор хаалаа, цаг нь амжихгүй боллоо гэж хэлээд хэргээ аваад яваад өгдөг;

26. Мэдээ мэдээллийг хуулийн дагуу хэвлэл мэдээллээр болон өмгөөлөгч нарт адил тэгш мэдээлдэг болмоор байна. Онд хүнд хэргийн талаарх мэдээ мэдээллийг хэргийн гэрч, хохирогч нарт хамаагүй мэдээлэхгүйгээр шүүх хуралдааны үеэр дэлгэдэг болмоор байна. Одоо цагдаагийн байгууллага онц хүнд хэргийн нотлох баримтыг гэрч, хохирогч нарт мэдээлээд байна. Би үүний эсрэг талд нь зогсдог;

27. Хөнгөн гэмт хэрэгт өмгөөллийн үйл ажиллагааг ихэвчлэн явуулдаггүй. Хүмүүс өөрсдийн хайхрамжгүйгээс болоод хөнгөн гэмт хэрэгт ял шийтгэгддэг. Хуульчдын хорооноос өмгөөллийн үйл ажиллагааны талаар сурталчилмаар байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цагдан хорихтой холбогдсон мэдээллийг ил тод болгомоор байна. Ерөнхийдөө энэ байгууллагаас тодорхой мэдээлэл авч байсан удаа байхгүй;

28. Шүүхийн шатанд хэрэг шилжих үед эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нар хэрэг аль шүүх рүү шилжсэн болох, хэрэгт шаардлагатай байцаалт хэн өгөөгүй эсэхийг мэддэггүй. Шүүх үйл ажиллагаагаа нээлттэй болгож оролцогч нарт цаг алдалгүй мэдээлдэг болох;

29. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага сэжигтэн яллагдагч нарын ар гэрт холбогдох мэдээллийг хурдан шуурхай дамжуулдаг болмоор байна. Тухайлбал цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч хэзээ суллагдсан, эрүүл мэндийн байдал зэргийг мэдээлдэг болмоор байна;

30. Мөрдөн байцаалтын ажиллагаанд хэргийг шуурхай шалгадаг арга тактикт шилжих шаардлагатай байна. Хангалттай нотлох баримт цугларсан байхад үл ялих зүйлээр шалтгалан хэргийг прокурор, шүүхийн шатнаас буцааж байна. Энэ явдлаас болж үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхол хөндөгдөж байна;

31. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хорих ангиудын хаяг байршил, хоригдогчтой уулзах эргэлтийн цагийн талаарх мэдээллийг нээлттэй болгомоор байна. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын харьцааны соёл харьцангуй сайжирсан ч хэрэг мөрдөн шалгах арга барил нь хоцрогдож байна;

32. Сэжигтэн, яллагдагчдийг бүх талаар, бүх төрлийн мэдээллээр нээлттэй хангах;

33. Явц байдал;

34. Боломжтой, бүх зүйл нээлттэй ил тод байх боломжийг бүрдүүлж өгөх хэрэгтэй;

35. Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, хэргийг бусад этгээдэд шилжүүлсэн эсэх;

36. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

37. Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөл, нөлөөлсөн хүчин зүйл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар өгсөн мэдээ, мэдээлэл;

38. Үйлдсэн хэргийн талаар болон урьдчилан сэргийлэх ажиллагаа;

39. Гомдол, мэдээллийг ил тод болгоод зогсохгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессийг цахимаар харах боломжтой байх хэрэгтэй. Жишээ нь, мөрдөн байцаагч нь энэ 7 хоногтоо шилжүүлнэ гэсэн ч 3-4 долоо хоног болдог явдал байна. Мөн хэрэг харьяаллын дагуу шилжүүлсэн гэж мөрдөн байцаагч, прокурор хэлээд хэргийг түдгэлзүүлээд хав дарсан тохиолдолд ч гарсан. Тэгэхээр хэргийг шалгах ажиллагаа ямар үе шатанд, хэн гэдэг албан тушаалтанд байгааг цахимаар хардаг байх шаардлагатай;

40. Хүсэлт, гомдол хүлээн авч шийдвэрлэх албан тушаалтанг тодорхой болгох, түүний шийдвэрт гомдол гаргах, давж заалдах, хянуулах боломж, уг ажиллагааны хугацааны талаарх мэдээлэл иргэдэд ил байх;

41. Хүсэлт, гомдол шийдвэрлэлтийн талаар зайлшгүй эргэж мэдээлэх шаардлагатай;

42. Иргэдээс цагдаагийн байгууллагад хандан гаргасан гэмт хэргийн талаарх гомдлыг хүлээн авч холбогдох ажиллагаа хийх, зохих шалгалтын ажиллагаа явуулахаас цааргалах, хойрго хөшүүн хандах, огт шалгалт явуулахгүйгээр гомдол мэдээлэл хүлээн авдаг ажилтан тухайн асуудлыг эрүүгийн хэрэг үүсгэн шалгах эсэхийг “дур мэдэн” шийдвэрлэх тохиолдол бүх хэлтэс, газарт маш түгээмэл болсон (Асуулгад хамааралтай эсэхийг мэдэхүй байна);

43. Цагдаа, шүүх, прокурор зэрэг байгууллага өөрсдийн албан ёсны цахим хуудастай байдаг ч өөрт ач холбогдолтой зарим мэдээллийг олж авч чаддаггүй. Тухайлбал, өргөдөл, гомдол хүлээн авагч болон туслахын утасны дугаар, албан тушаал, зэрэг дэв, цол зэрэг мэдээлэл хаалттай байдаг. Түүнчлэн, албан хэрэгцээндээ ашигладаг дүрэм, журам, аргачилсан зааврууд зэргийг олж харах боломж хомс. Ер нь байршуулдаггүй. Иймээс дээрх мэдээллийг нээлттэй байршуулах нь зүйтэй гэж үзэж байна. Зарим тохиолдолд цагдаа, прокурор, шийдвэр гүйцэтгэгч нарын утасны дугаарыг жижүүрээс асуухад “хэлж өгөхгүй, боломжгүй эсхүл заавал өөрийн биеэр ирж авах” талаар шаардлага тавьдаг зэрэг нь хүндрэл учруулж чирэгдэлтэй санагддаг. Мөн шинээр томилогдсон дарга, албан хаагчдын талаарх мэдээллийг шинэчилж оруулж байх шаардлагатай санагддаг. Ялангуяа цагдаа, прокурорын томилгоо ойр ойрхон солигддогтой холбоотой. Байгууллагууд цахим хуудасныхаа мэдээллийг шинэчилж, агуулга сайтай болгох шаардлагатай;

44. Хууль зүйн үндэслэл бүхий баримт сэлт боловсруулах, шаардлагатай мэдээ мэдээллийн цаг тухай бүрт нь хэргийн оролцогчид мэдэгдэх, холбоо тогтоон тайлбарлаж өгч байх шаардлагатай байдаг;

45. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, шүүхийн шатан дахь ажиллагааны талаарх мэдээллийг нээлттэй болгох;

46. Хэрэг, маргаан, зөрчлийг тал бүрээс нь яллах, цагаатгах талаас нь хандаж байх хэрэгтэй;

47. Өмгөөлөгчөөс гарагасан хүсэлтийг бодитоор үнэлж дүгнэн нээлттэй байлгах;

48. Мэдээ мэдээлэл нээлттэй байх нь зөв ч хэн нэг хүний хувийн асуудлыг хэн дуртай нь орж үзэх зохимжгүй гэж бодож байна. Зохицуулалт байх хэрэгтэй;

49. Гомдол, мэдээлэл, хэргийг шалгаж буй алба хаагчийн сэтгэл зүй, асуудалд хандах хандлага, зүй ёсыг танин мэдэх чадвар, сэтгэлгээ болон хуучин хэвшмэл хэлбэртэй хандлага, харилцаа, үйл ажиллагааг өөрчлөх сургалт дутагдалтай байгааг анхаарч ажилласнаар ур чадвар, мэдлэг хариуцлага, үнэт зүйлс сайжирна.

--0--

UIH.MN
СУДАЛГААНЫ САН